

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР /МЯГМАР
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-4
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	5-
	1.Эрх зүйн дүгнэлт гаргуулах тухай /Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар/	5-9
	2.“Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2021.02.19-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/	9
	3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	9-34
	4.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан, өрийн удирдлагын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох	34-50

Хоёр.*“Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2021.02.19-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

“Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөх асуудлыг салбарын сайдыг иртэл түр хойшлуулав./12.05 цагт/

Гурав.*Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Г.Гийхнаран, мөн хэлтсийн мэргэжилтэн Ц.Номингэрэл, Т.Энхжаргал, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, мөн газрын Цахим худалдан авах ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Н.Цэрэнсамбуу нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Ш.Раднаасэд, Х.Баделхан, Ж.Батжаргал, Д.Өнөрболор, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы

нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан, өрийн удирдлагын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, мөн хэлтсийн мэргэжилтэн Д.Хашчулуу, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан, өрийн удирдлагын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Баделхан, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Байнгын хорооны гишүүд Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан, өрийн удирдлагын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсов.

шилжүүлэх гэсэн үндэслэл нь бол ганцхан татварын байцаагчаас бусад нь орж ирээгүй байсан учраас бол тэгсэн юм байна.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Гишүүд асуулт асууж үг хэлж дууслаа.

Ингээд санал хураалт явуулъя. Эрх зүйн дүгнэлт гаргах асуудлыг эрх зүйн дүгнэлт гаргахтай холбоотой энэ асуудлыг дэмжье гэсэн асуудлаар санал хураалтаа явуулъя.

Шилжүүлж байгаа. Шилжүүлж байгаа биш эрх зүйн дүгнэлт гаргах эсэх асуудлаар санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулъя. Ингээд нийт санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 7 гишүүд дэмжиж эрх зүйн дүгнэлт гаргах шаардлагатай гэсэн энэ шийдвэрийг бол Байнгын хорооноос гаргаж байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Ингээд эрх зүйн дүгнэлт гаргуулах асуудлыг хэлэлцэж дууслаа.

Хоёр дахь асуудалдаа оръё.

Даян дэлхийн ногоон хөгжлийн институци эрх зүйн статус, эрх ямба, дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институци хоорондын хэлэлцээрийн төсөл, Засгийн газар 2021 оны 3 сарын 19-ний өдөр ирүүлсэн зөвшилцөх санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэх.

Энэ асуудлыг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг оруулъя. Хэлэлцээрийн нэршлийн талаарх танилцуулгыг Байгаль орчин, аялал, жуулчны сайд Б.Бат-Эрдэнэ танилцуулна. Бат-Эрдэнэ сайд алга байна. Ингээд Даян дэлхийн ногоон хөгжлийн институц, эрх зүйн статус, эрх, ямба дархан эрхийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Даян дэлхийн ногоон хөгжлийн институт хоорондын хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг хийх салбарын сайд Бат-Эрдэнэ сайд байхгүй учир энэ асуудлыг хойшлууллаа.

Дараагийн асуудалдаа оръё. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газар 2022 оны 12 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал байгаа.

Ингээд төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Сангийн сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг анх 2000 онд хуулиар зохицуулж эхэлсэн бөгөөд хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийг 2005 онд баталсан ба тус хуульд 32 удаа нэмэлт, өөрчлөлт орж байжээ. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөр 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан тендер шалгаруулалтын үйл ажиллагааг хиймэл оюун ухаан, сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгах, мэдээллийн ил тод байдал, худалдан авах ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх тендер шалгаруулалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, гэрээ шууд байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгох, гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг дээшлүүлэх зэрэг зорилтуудыг хангуулах хууль эрх зүйн орчныг шинэчлэх шаардлага үүсэж байна аа.

Түүнчлэн тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр хуулийг шинэчлэн найруулах тусгай зөвлөмж гарсан бөгөөд Улсын Их Хурлаас шинэ сэргэлтийн бодлого баталсантай холбогдуулан шинэ сэргэлтийн бодлого батлах тухай Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын Монгол Улсын Их Хуралд 2022 онд үе шаттайгаар өргөн мэдүүлж хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга гэж тусгагдсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын хүрээнд тендер шалгаруулалт дахь хүний оролцоог бууруулах, нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх, тендер шалгаруулалтыг түргэн шуурхай зохион байгуулах, хариуцлагын тогтолцоог шинэчлэх гэсэн үндсэн агуулгыг тусгаж, хуулийн төслийг боловсрууллаа.

1. Технологийн дэвшилд тулгуурлан тендер шалгаруулалтыг хүний оролцоог багасгая энэ зорилтын хүрээнд Засгийн газраас худалдан авах ажиллагааг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2011 оноос эхлэн тасралтгүй хийж байгаа боловч тендер шалгаруулалтыг цахим технологид тулгуурлан бүрэн шилжүүлэх шаардлага байсаар байна. Одоогийн байдлаар тендер оролцогчдын бүрдүүлдэг материалаас зөвхөн 18 хувийг цахим хэлбэрээр төрийн болон хувийн хэвшлийн мэдээллийн сангаас татан авч, тендерийн үнэлгээнд харгалзан үзэж байгаа бол үнэ үүнийг 70 хувьд хүргэх агуулгаар хуулийн төсөлд тусгалаа.

Ингэснээр худалдан авах ажиллагаан дээр хүний оролцоог 60 хүртэл хувиар бууруулна. Мөн тендер оролцогчдын бүрдүүлдэг цаасан материал, бичиг цаасыг 10 дахин бууруулах ийм боломж байгаа юм.

2. Худалдан авах ажиллагааг төлөвлөх, шатнаас эхлэн гэрээ байгуулах, гэрээний гүйцэтгэлийг хянах хүртэлх үе шатыг цахим системээр зохион байгуулна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 2778 захиалагч байгууллагаас 15792 тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулж байна. Худалдан авах ажиллагааны цахим системд нийт 16780 хуулийн этгээд бүртгүүлэн тогтмол тендер

шалгаруулалтад оролцож байна. Улсын хэмжээнд бүх шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах бөгөөд захиалагч байгууллагын өдөр тутмын хэрэгцээт бараа, үйлчилгээг цахим дэлгүүрүүдээс худалдаж авах оролцоход хялбар, богино хугацаанд тендер шалгаруулалт зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэхээр зорьж байна. Энэ хүрээнд бүртгэлийн тогтолцоог захиалагч, ААН бараа, үйлчилгээ зэргээр төрөлжүүлж бүрдүүлнэ ээ.

3.Худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлнэ. Тендер шалгаруулалтын бүх үе шатыг ил тод болгож, тендерт оролцогчид шалгарсан оролцогчийн ирүүлсэн материал болон тендерийн үнэлгээний үе шаттай танилцах боломжийг олгоно. Мөн иргэд, олон нийт болон эцсийн хэрэглэгч аливаа худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтийн талаар санал хүсэлт гаргах, санал хүсэлтийн дагуу гэрээний үүргийг хянах эрх зүйн орчныг бий болгоно. Нөгөөтэйгүүр гэрээний мэдээллийн санг ил тод болгож, аль компани ямар ажлыг хийж байгаа. Тухайн гэрээний гүйцэтгэл, санхүүжилтийг олон нийтэд нээлттэй мэдээлэх зориулалтыг шинээр тусгалаа.

4.Худалдан авах ажиллагаанд оролцогч болон шийдвэр гаргах этгээдийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтийг тусгалаа. Үүнд сонирхлын зөрчлөөс сэргийлэх зорилгоор захиалагч тендерийн баримт бичиг боловсруулах болон тендерийг үнэлэх ажлын хэсгийг тус тусад нь байгуулах хууль бус шийдвэр гаргасан захиалагч үнэлгээний хороонд зайлшгүй хариуцлага хүлээлгэх хариуцлагатай, чадвартай компанийг дэмжихийн тулд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлдэггүй, хуурамч материал бүрдүүлэн тендер шалгаруулалтад оролцдог хариуцлагагүй ААН-үүдийг хар жагсаалтад үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн түвшинд мэдээллээр бүртгэж, олон нийтэд ил тод мэдээлж байна. Тендерийн баримт бичигт тавигдах шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож, ингэснээр өрсөлдөөнийг хязгаарлах, бусад давуу байдал олгох боломжийг багасгах ач холбогдолгүй баримт материал ирүүлэхийг тендерт оролцогчоос шаардлагыг хязгаарлах зориулалтыг бий болгохоор хуулийн төсөлд тусгалаа.

5.Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан эх оронч худалдан авалтыг дэмжих зорилтыг хэрэгжүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд мөн тусгалаа.

Энэ хүрээнд дотоодын үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгчдийг дэмжих, дэмжиж байгаа одоогийн хуулийн сайн зохицуулалтуудыг бүрэн хадгалж, давуу эрхийн зөрүү тооцох аргачлалыг боловсронгуй болголоо. Мөн дотоодын барааг импортын бараатай өрсөлдүүлэхгүй ба зөвхөн Монгол бараа үйлдвэрлэгч хоорондоо өрсөлдөнө.

Засгийн газар чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтыг баталж, чанартай, стандартад нийцсэн дотоодын барааг цахим дэлгүүрт байршуулж, төрийн байгууллагад тогтмол нийлүүлэх боломжийг хуулиар бий болгоно оо.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайдад баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Ганболд Гийхнаран Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга, Цэдэнбалын Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Нүрэнзэдгомбын Цэрэнсамбуу Төрийн худалдан авах ажиллагааны газрын Цахим худалдан авах ажиллагаа Мэдээлэл технологийн хэлтсийн дарга, Даваадоржийн Номингэрэл Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн мэргэжилтэн, Түмэнжаргалын Энхжаргал Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн ажилтан. Хуулийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгье. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа.

Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

Г.Амартүвшин: Гишүүдийн энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Жавхлан сайдаас нэг хэдэн зүйл асуугаад тодруулчихъя. Ер нь бол амьдрал дээр тендерт оролцож байгаа компаниуд нь ялагдсан компани нь ялсан компаниа унагах гэж гомдол гаргадаг, шүүхдэлцдэг, дахин дахин хоорондоо маргалдсаар байгаад нөгөө худалдан авалтын процессыг удаашруулдаг, замхруулдаг. Тэр хооронд нь цаг хугацааны байдлаас болоод тендерийнхээ үнэ өртөг нь ч хүртэл өсөөд явдаг ийм асуудал байнга гардаг.

Тэгэхээр энэ оруулж ирж байгаа хуулийн төслөөр энэ маргааныг таслан шийдүүлдэг юм уу? Энэ удаашруулдаг арга барилыг нь багасгасан тийм зүйл заалт байна уу? Энийг ер нь яаж шийдэхээр болсон бэ?

Хоёрдугаарт тендергүй шууд гэрээ хийх нөхцөл мэдээж хэрэг байдаг. Энэ хуулийн төсөл дээр тэр нь яаж тусгасан байна? Ямар нөхцөлтэй тендергүй шууд гэрээ хийх үү? Тэрийг нь яаж шалгаруулах вэ? Мэдээж хэрэг шууд гэрээ хийхээр бол хардалт сэрдэлт үүсдэг. Тийм болохоор энийг яаж урьдчилан сэргийлэх вэ? Сүүлийн асуулт нь болохоор тендерийн баталгаа ер нь бол улсын тендер юм уу? Орон нутгийн тендерт оролцож байгаа компаниуд бол заавал тендерийн баталгаа гаргах шаардлагатай байдаг.

Өнөөдрийн нөхцөл байдалд бол арилжааны банкууд ер нь бол зээл гаргах дээрээ их хязгаарласан байгаа. Тэгээд ийм тохиолдолд тендерийн баталгааны нөхцөл ер нь өөрчлөгдсөн үү, үгүй юу?

Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Амартүвшин гишүүний асуултад Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Энэ маргаан үүсдэг ээ. Гэхдээ сүүлийн жилүүдэд. Сүүлийн жил гэдэг нь би сүүлийн 5-6 жилийн статистикаар энэ тоо бол эрс багасаж байгаа юм. Жил бүр Монгол Улсын хэмжээнд нийтдээ нэг 20000 орчим максимумдаа 22000 ийм тендер гэрээнүүд хийгддэг ийм статистиктай. Энд төрийн хөрөнгө оруулалт, төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар тэр дотор чинь нийслэл бол маш том. Ингээд төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниуд Монгол талын ингээд олон улсын гэрээгээр мөн худалдан авах ажиллагаанууд хийгддэг. Ингээд 5-6 төрлийн энэ хуулиараа зохицуулагддаг ийм хэмжээний гэрээ хийгддэг юм байна аа.

Эндээс харин ирж байгаа маргаан бол маргаан өмнө нь бол нэг 5-10 хувьтай ингэж ирдэг байсан. Одоо нэг хувь хүрэхгүй ингэж багасаж ирсэн байгаа. Өөрөөр хэлбэл энэ маргаан таслах процесс нь өөрөө хурдан шуурхай, ил тод болж байгаа.

Дээрээс нь бас Тендерийн хууль маань хэрэгжилт нь бас сайжирч ирж байна л гэсэн ийм үзүүлэлт. Тэгэхээр байгаа зохицуулалт нь бол худалдан авах үйл ажиллагааны бодлогыг хариуцдагийн хувьд Сангийн яаман дээрээ байдаг энэ процессоороо бол үргэлжилнэ. Энэ нь бол өөрөөр хэлбэл урьдчилсан хэлбэрээр гаргадаг шийдвэр. Энийг 2 тал зөвшөөрөхгүй бол дараагийн шатанд шүүх рүү явдаг. Энэ асуудал нь бол нээлттэй хэвээрээ. зохицуулагдаж байгаа. Шууд гэрээний хувьд ажлын хэсгээс нэмэлт заалтуудыг нь уншаад өгөөрэй. Шууд гэрээний хувьд бол ийм байгаа. Нэмэлт шууд гэрээний нөхцөл бол байхгүй, орж ирээгүй гэсэн үг.

Хуучин шууд гэрээгээр хийгдэх зохицуулалтууд, ер нь бол хууль дээр байгаа тэрийг харин илүү ил тод, тэндээс үүсдэг эрсдэлүүдийг бууруулах ийм зохицуулалт заалтууд орж ирсэн гэсэн үг. Би дахиад хэлье. Шууд гэрээ хийх нэмэлт нөхцөл бол орж ирээгүй гэсэн үг шүү. Одоо байгаа эрсдэлийг нь бууруулах. Илүү ил тод болгох, хүрээг нь хумих ийм зохицуулалт орж ирж байгаа гэсэн үг. Баталгааны хувьд ингэж байгаа. Өнгөрсөн намар Улсын Их Хурал энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Энэ бол цаг үеэ олсон, маш сайн, ийм зохицуулалт болж чадсан. Зөвхөн 4 төрлийн баталгаа гаргадаг. Эндээс зөвхөн чанарын баталгааг нь бол бид хэвээр үлдээгээд бусад баталгаануудыг нь 2-4 дахин бууруулсан. Одоо жишээ нь гүйцэтгэлийн баталгаа 2 хувь байдаг. Юунаас нийт төсөвт өртгөөс нь авдаг байсан бол тухайн жилд санхүүжих дүнгээс 0.5 хувь өөрөөр хэлбэл тендер гэрээ хийх үедээ 2, 3, 4, 5 жил ч үргэлжилдэг, энэ нийт төсөвт өртгөөсөө 2 хувийг нь байршуулчихаад, тэгээд бараг жилдээ авдаг санхүүжилт нь нөгөө банкн дээр аваачиж тавьж байгаа баталгаанаасаа бага дүнтэй тэр ийм тохиолдлууд байдаг. Энэ бол бүрэн арилсан.

Тэгэхээр эдгээр сайн заалтуудыгаа бол бид нар авч үлдэж байгаа юм. Хэвээрээ хадгалагдаж байгаа гэсэн үг.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг нэмж хариулъя. Нэгдүгээр номер.

Ц.Батзул: Сайн байцгаана уу? Ажлын хэсгийн гишүүн Батзул байна. Гишүүний асуултад хариулъя. Сая тендерийн баталгаан дээр нэмээд хэлэхэд сүүлийн нэмэлт, өөрчлөлтөөр нь 2 байсныг нь 4 дахин бууруулаад 0.5 хувь болгосон. Мөн даатгалын сертификатаар бас тендерийн баталгаа гаргаж болохоор хуулийн нэмэлт, өөрчлөлт орсон. Тэрийг нь мөн хадгалаад явж байгаа. Нэмээд Засгийн газрын үнэт цаас нь богино хугацаанд үнэт цаасаар нь тендерийн баталгаа гаргахаар бас ийм сонголтуудыг нь хуулиар бол оруулж ирж байгаа. Нэмээд гэрээ шууд байгуулах аргын

хувьд бол хуулийн 34 дүгээр зүйлээр нарийвчлан зохицуулсан заалтуудыг нь 2 хуваагаад нэг эх үүсвэртэй болон гэрээ шууд байгуулах гээд илүү ил тод нээлттэй байхаар хуулийн төсөлд оруулсан. Одоо бол нөгөө нуугаад нэг хүнтэй шууд гэрээ байгуулдаг ийм боломжийг бол хуулиар нь хааж өгч байгаа. Ямар ч аргыг хэрэглэсэн бай бүх тендерийн урилга бүгд цахим систем дээр нээлттэй байна.

Харин яаралтай нэн яаралтай гэдэг хугацааны хувьд өөр байх учраас тендер саналаа хүлээж авах хугацааг нь ялгамжтай тавьсан байгаа. Тэгэхээс биш мэдээлэл нь бол бүгдэд нээлттэй, ил тод байхаар бол хуулийн төсөлд тусгасан. Энэ агуулгаараа бол гэрээ шууд байгуулах аргын нээлттэй, ил тод байдлыг нь бол шинэчилсэн найруулгаар нь нэмэгдүүлж өгсөн. Нэг шинэлэг заалт нь юу вэ гэхээр нэг эх үүсвэртэй худалдан авах ажиллагаа буюу төрд хэрэгтэй зарим онцгой бараа, ажил үйлчилгээг нь зөвхөн цор ганц этгээд үйлдвэрлэдэг байх юм бол тухайн онд шууд нэг эх үүсвэртэй худалдан авалт гэрээ хийх боломжтой гэдэг шинэ зохицуулалтыг нь хийж өгсөн.

Г.Тэмүүлэн: Амартүвшин гишүүн нэмж тодруулъя.

Г.Амартүвшин: Тендертэй холбоотой бас нэг юм асуучихъя. Жавхлан сайд жишээлбэл зарим тендер худалдан авалтууд давтан худалдан авах шаардлагатай байдаг шүү дээ 1 жилийн нэг удаагийнх биш. Тэгэхээр 2, 3 жил үргэлжлээд худалдан авах тийм боломж байдаг уу? Энэ бол нөгөө ААН-д бас аягүй хэрэгтэй байдаг. Урт хугацааны гэрээ байх тусам тэд нарын хувьд санхүүжилтийн өртөг нь багасдаг. Бизнес нь өргөжих боломж нь гардаг болохоор энэ нь энэ хуулийнхаа төсөлд яаж тусгасан байгаа юм?

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд асуултад хариулъя.

Б.Жавхлан: Энэ маш чухал асуулт шүү Амартүвшин гишүүн ээ. Энийг хэдүүлээ хэлэлцэх эсэхдээ ч тэр цаашдаа энэ хуулиа ингээд батлах явцдаа энийг маш ил тод, олон нийт рүү энийг сайн сурталчлах хэрэгтэй. Тэрэн дээр яагаад би итгэлтэй байгаа вэ гэхээр энэ хуульд орж байгаа дэвшилтэт томоохон өөрчлөлтүүдийн нэг нь ерөөсөө яг энэ юм байгаа юм. Өөрөөр хэлбэл одоо жилд 22000 тендер бараа, ажил үйлчилгээ худалдаж авах ийм процесс болж байгаа юм. Энүүний зарим жилүүдэд бүр 70 хувь нь дандаа худалдан авах, байшин барилга биш дандаа худалдаа авах дахин давтагддаг юмнууд авсан байхгүй юу. Тэгэхээр энэ хуулиа хэрэгжүүлж, бид нар 2-3 жилийн дараа ингээд хэвшиж чадвал бүр яг 60-70 хувиар, жил бүр тендер зарах ажиллагаанууд буурах юм байгаа юм. Яг таны хэлсэнтэй холбогдуулж ийм 2 чиглэлээр цахим болгох ил тод болгож байгаа энэ яг бүлэг, тэр процессууд дотор энэ зохицуулалтууд бол хийгдэнэ. Нэг гэрээ хийгдлээ.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайдын микрофоныг нэмье. Нэмж 1 минут өгье.

Б.Жавхлан: Нэг тендер зарлаад, нэг худалдан авагчаас тухайн жилдээ л та байнга худалдаж аваад байна. Энэ зохицуулалтаар яаж байна вэ гэхээр Засгийн газраас жишээ нь дотооддоо үйлдвэрлэж байгаа бараа материалуудыг ингээд зарлачихна гэсэн үг. Амартүвшин гишүүн ээ. Тэгээд зарлачихна. Эсвэл арай олон улсад, хүлээн зөвшөөрөгдсөн, стандартад нийцсэн ийм бараа материалуудыг бид нөгөө цахим дэлгүүртээ хийчихнэ. Тэгээд л яг тэнд зөвшөөрөгдсөн үнээр

баталгаажсан, хэд хэдэн шалгуур тавиад Засгийн газар ороод батлагдсан тэр бараа материалыг бол тэндээс бол шууд худалдан авалтуудаа хийгээд яваад байж болно. Хэдэн ч эх үүсвэр, хэдэн ч компаниас худалдаж авч болно, нэг үнээр зөвхөн үнээрээ уралдаад л тэр компаниуд нь нээлттэй яваад байна гэсэн үг. Тэр нь бүр 3 жил ч гэрээ хийж болно гэж байна. 3 хүртэл жилээр, 1 жил ч биш.

Тэгэхээр энэ бол өөрөө энэ хуулийн шинэчилсэн найруулгын нэг томоохон дэвшилтэт олон улсын стандарт руугаа явж байгаа алхам болно. Дээрээс нь дотоодын үйлдвэрлэгч нарыг дэмжих, эх оронч худалдан авалт хийх маш том боломжийг нээнэ гэсэн үг дотоодод үйлдвэрлэж болдог, дотоодод үйлдвэрлэж болдог дээр 2 л асуудал үүсдэг. Үнийн асуудал мөн яг шаардлагатай тоо хэмжээнд тогтмол нийлүүлж чадах уу, үгүй юу гэдэг. Эдгээрийгээ үнэхээр яг шаардлагаар хангаж чадаж байна уу гэвэл, тухайлбал Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас тэр дотоодын үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний жагсаалтыг гаргаж ирээд Засгийн газраар орж жагсаалтаа батлуулаад л яг тэндээс нь гаднын импортын ижил төстэй бараануудтайгаар өрсөлдөхгүйгээр тэндээсээ ингээд худалдан авалтуудаа хийгээд явах ийм боломжуудыг нээж өгч байгаа юм.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: 2, 3 асуулт байна.

Сайжруулсан байх гэж найдаж байна. Гэхдээ хэд хэдэн юмнууд байна. Энэ дотор энэ хуулийн чинь үйлчлэх хүрээ нь улсын болон орон нутгийн төсөвт байгууллага л яваад байна шүү дээ айн? Төрийн өмчийн компанид орох уу? Аж ахуйн тооцоонд одоо энэ Авто тээврийн үндэсний төв гэх мэтчилэн бүгд орж байгаа юу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ Оюутолгой, Эрдэнэт чинь бүгд явж байгаа юу? Эрдэнэтийн юм чинь, та 50 хувиас дээш болж байна. Энэ түрүүн тэр хувьчлалын дуудлага худалдааны тендерийн арга дээр чинь нэг маягийн эх үүсвэрээс гэнэ үү? Нэг эх үүсвэрээс худалдан авах гэдэг дотор чинь 2, 3 юм байна аа. Энэ 2005 оны хуульд байгаагүй заалт, тийм үү? Шинээр оруулж ирж байгаа юм байна? Энэ дотор чинь ингээд явахаар 10.8, 10.10 ингээд шууд худалдан авалтууд явах нь байна шүү. Доторх заалтуудын та нь уншсан уу? Энэ дотор чинь ингээд дахиад юу явж байна гэхээр төрийн өмчит аж ахуй нэгж байгууллагуудын тоног төхөөрөмжүүд 31, 36.1.6 солих, засварлах, үйлчлэх гээд.

Ингээд 36.1.12, 36.1.2 гээд эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгийн их юм чинь энэ дээр явж байгаа шүү дээ 20 хувиас хүү хэтрээгүй гээд энэ худалдаж авч байгаа эмүүд чинь чанар стандартын шаардлага хангахааргүй юмнууд байгаад байгаа юм. Энийг бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ бид нар. Доод үнийн гэдэг ийм зарчмаар ийм худалдан авалт явагддаг. Тэгээд энэ дотор чинь дахиад энийгээ үргэлжлүүлээд 3, 4 жилээр хийх ийм нөхцөлүүд чинь энэ дотор ороод ирчихлээ л дээ яг энэ аргаар чинь. Энийг ер нь яаж харж байна аа?

Энэ нэг эх үүсвэрээс худалдан авах гэдэг дээрээ жаахан цензур тавьж өгөхгүй бол энэ чинь бол их л будилааны хөрөнгө болно доо.

Дараа бас нэг асуулт байна аа. Энэ урьдчилан мэдэх боломжгүй нөхцөлд нөхцөл байдлын улмаас шууд гэрээ байгуулж болно оо гэж байна. Тийм үү? Тийм. Энэ дотор нь юу байх юм гээд би одоо нөгөө нэг иргэний хуульд байдаг онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын үед ч юм уу гэж ойлгосон чинь энэ нь дахиад зардалтай байх юм. Урьдчилсан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас авахаар бол ингээд бид шууд авч байна гээд ингээд нэг шууд гэрээ байгуулах нөхцөлүүд чинь энэ дотор яваад байна.

Энэ чинь бол ард талдаа бол байх шиг байгаа юм. Яаралтай хэрэгцээт гээд Тийм. Энэ чинь дахиад энэ дотор ороод ирчихсэн байна.

Гурав дахь юм нь энэ нэг хариуцлагын юмаа энэ дотроо хэр сайн суулгасан юм бэ? Тендер авчихдаг сургууль, цэцэрлэг, эмнэлэг гээд. Очоод барьдаггүй, ингээд 4, 5 жил болчихсон юмнууд байна шүү дээ. Энийг хамгийн их ярьж байгаа хүн энэ Тэмүүлэн дарга ярьж байгаа гэсэн. Танай нөгөө эмнэлэг баригдсан уу? Нэг ямар сум билээ? Манайх дээр нэг Алтай сумын эмнэлэг, Халиун сумын эмнэлэг ингээд дотуур байр 2 алга болчихсон. Архангай аймгийн Хангай сум дандаа нэг этгээд авсан байгаа байхгүй юу. Тэгээд энэний араас хөөцөлддөг хүн байхгүй. Боловсролын яам мэддэг юм уу гэх Боловсролын яам нь бид нар бичгээ өгчихсөн гэдэг. Яг энэ дээр энэ хариуцлагыг нь тодорхой болгож өгөхгүй байгаагийн улмаас энэ нөхдүүдэд чинь ингээд энд тэнд тендер аваад ажлаа хийхгүй, тэгээд энэ урьдчилгаа хэдэн төгрөгийг нь авдаг юм уу хийсэн болоод л ингээд хаячихаад яваад өгч байгаа байхгүй юу.

Энэ заалтууд чинь энэ дээр хэр хаагдсан бэ? Би бодохдоо бол 2005 оны хуулиар чинь та нар зовлон бэрхшээл болдог юмнуудаа энэ дотор засаж илүү тодорхойгоор оруулж ирсэн болов уу гэж бодох юм.

Г.Тэмүүлэн: Асуултад ажлын хэсгээс хариулъя. Батзул нэгдүгээр номер.

Ц.Батзул: Раднаасэд гишүүний асуултад хариулъя.

Ажлын хэсгийн гишүүн Батзул байна. Эмийн болон энэ чанар стандартын асуудал дээр бид нар шинэ зохицуулалт оруулж ирж байгаа нь тендерт оролцохоос тендерт санал болгохоос нь өмнө бараа ажил үйлчилгээг нь стандарт шаардлагыг нь хангаж байгаа каталог бий болгоод зөвхөн Каталогт бүртгэгдсэн барааг нь тендерт оруулдаг эрхийн зөрчилгүй буюу хуурамч бараа нийлүүлэх боломжийг нь бол энүүгээр хааж байгаа. Мөн зөвхөн каталог дээр тусгай шаардлага Монгол Улсад мөрдөж байгаа стандартыг хангасан бараануудыг бүртгэх замаар энэ чанаргүй бараа болон чанаргүй эм, эмнэлгийн хэрэгслийн асуудлыг ер нь бол шийдэж чадна.

Тэгэхдээ нөгөө талдаа тендерээр бид нар чанаргүй эмийн асуудлыг нь зохицуулна гэхээр бас болохгүй байгаад байгаа юм. Тухайн салбарынхаа хууль тогтоомжийн хүрээнд чанаргүй эмийг нь импортлох асуудал, үйлдвэрлүүлэх асуудал дээр нь хяналтаа сайжруулах шаардлагыг бид нар бас салбарын яаман дээр нь хэлэхгүй бол жишээ нь Монголд үйлдвэрлэж байгаа парацетмол нь бол чанаргүй гэсэн мөртөө цаашлан үргэлжлүүлэн үйлдвэрлүүлээд л байдаг, асуудал нь бол тендерийн биш нөгөө тухайн салбарынх нь хууль тогтоомжоор нь илүү зохицуулах нь зүйтэй гэж бас харж байгаа.

Хариуцлагын асуудал дээр бол бид нар компаниудын бүх түүхийг нь систем дээрээ нээлттэй, ил тод бүртгээд явна. Ямар ажиглах хүчинтэй юм? Ямар машин механизмтай хүчин чадал, нөөц бололцоо өнөөдрийн байдлаар ямар байгаа юм? Тэгээд урьд нь ямар гэрээ хэрэгжүүлсэн юм гэдэг бүх түүхийг нь давхар хөтлөөд явах бөгөөд дараагийн тендерт орж ирэх үед нь өмнө нь хэрэгжүүлсэн ажил туршлагынх нь асуудлыг нь дараагийн тендер нь харгалзаж үзээд нөөц бололцоо нь хүрэхгүй бол дахин гэрээ байгуулах эрхийг нь олгохгүй байхаар хуулийн төсөлд тусгасан байгаа. Баян Могод компанийг бол би өөрөө хяналт шалгалт хийгээд энэ 2020 онд нь байцаагчийн дүгнэлт гаргаад хар жагсаалтад орчихсон. Одоо бол хар жагсаалтад явж байгаа. Нэг эх үүсвэрээс худалдан авах ажиллагааны энэ арга нь бол зайлшгүй амьдрал дээр хэрэгтэй байгаа юм. Жишээ нь ковидын нөхцөлийн үед бол сая хуулиар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн 34 дүгээр зүйл дээр вакциныг бол худалдаж авах боломжтой гэсэн мөртөө яаж худалдаж авах арга нь бол ойлгомжгүй. Тендерийн баталгаа шаардах юм уу, гүйцэтгэлийн баталгаа шаардах юм уу зөвхөн нэг цор ганц. Яг зөв, тийм тийм.

Тэр бас байгаа байгаа. Өөр нэмэлтээр илүү ойлгомжтой болгоод, тодорхой нээлттэй ил тод байдлаар нь явуулахаар хуулийн төсөлд. Хуулийн 35 дугаар зүйл болон 34 дүгээр зүйл дээр нь тусгасан байгаа.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн нэмж тодруулъя.

Ш.Раднаасэд: Яах вэ энэ бодвол ингээд хэлэлцүүлгийн шатанд засагдах юмнууд нь засагдах байх гэж бодож байна. Энэ дээр бол нэлээн нарийн юмнууд бас байгаа байх. Зүгээр хар жагсаалтад оруулаад ийм гэрээ байгуулчхаад зүгээр хаяад явчихсан аж ахуйнуудыг хар жагсаалтад оруулаад орхиж болохгүй ээ. Тэр бол тийм ач холбогдолтой биш байхгүй юу. Тэртэй тэргүй улсын төсвийн хэдэн зуун тэрбум төгрөг авчхаад бид нар хар жагсаалтад оруулчихсан гээд ингээд зүгээр сууж болохгүй шүү дээ. Энэ дотоодын үйлдвэрлэлийг ямар тохиолдолд дэмжих вэ гээд энэ дотор чинь байна.

Одоо энэ дотор чинь харахад 30 тэрбум хүртэлх ажил үйлчилгээ 3 тэрбум хүртэлх төгрөгийн 1 тэрбум хүртэлх төгрөгийн бараа, 300 саяын үйлчилгээ гээд бид нар энэ дээр ингэж дотоодын үйлдвэрлэл дээрээ хүртэл энийг заах ёстой юу, үгүй зөв үү? Уул нь дотоодын үйлдвэрлэлээ дэмжээд тэд үнэхээр 3 жилээр төлөвлөж болдог бол энэ одоо онцгой цэрэг, цагдаагийнхаа хувцсыг, гутал хувцсыг хийж байгаа компаниудыг. Ажлаа төлөвлөж сарын дотор нийлүүлэхээр урдаасаа орилж байгаа.

Асуултад хариулъя, Жавхлан сайд.

Б.Жавхлан: Би нэмж хариулъя. Ийм энэ бол төрийн өмчийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа материал, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Эрүүгийн хууль биш, Зөрчлийн тухай хууль биш, энэ хуулиар шийдэж чадах хязгаар нь тэр. Хар жагсаалтад оруулах л бид нар ийм арга хэмжээ авна шүү дээ. Тэр нь хэрвээ гэмт хэргийн шинжтэй зүйлүүд байвал тэр эрүүгийн бусад хангалттай олон хуулиудаараа энэ нь зохицуулагдаад ингээд явна. Ингэж явж ирсэн байгаа юм. Ер нь төрийн өмчийн энэ бараа материал худалдан авахтай холбоотой маш олон гэмт хэргүүд энэ хуулийн байгууллагуудад шалгагдаад шийдэгдээд ингээд явж байдаг юм

байна лээ. Саяын сүүлийн хэлснийг гишүүн яах вэ? Одоо ингээд хэлэлцэх явцад хуулийг хоёулаа дахиад өөрөө хуульч хүн сайн харна биз дээ? Таны яг хэлсэн зүйлтэй нь яг нийцэж байгаа асуудал шүү. Тэр чинь ийм байхгүй юу. Одоо гадаадын компанид орох босго нь 10 тэрбумын. Одоо 15 тэрбумын ажил дээр бол орж болно гэсэн үг байхгүй юу. Тэрийг нь 30 болгочхож байгаа юм.

30-аас дээш л гаднынхан орж болно. Гуч дотроо бол орж болохгүй бол гуч дотор бол дотоодын компаниуд хоорондоо өрсөлдөнө өө л гэсэн үг. Тэгэхээр эдийн засгийн боломж, компаниудын боломж бас нэмэгдэж байгаа учраас тэрийг нь бас суурийг нь тэлж өгч байгаа гэсэн үг. Тэлж өгөөд хамгаалж байна л гэсэн үг. Тэр 1 тэрбум хүртэл гэдэг чинь одоо 100 сая төгрөг байдаг байхгүй юу, худалдан авах. 100 сая төгрөгөөс дээш бол гадаадын компаниуд орж болно гэж байгаа босгоно, тэрийг нь нэг тэрбум болгоод, өөрөөр хэлбэл дотоодын компаниуд нэг тэрбум дотроо зөвхөн хоорондоо л өрсөлдөнө. Гаднынхан орж ирэхгүй гэж бас хамгаалж өгч байгаа асуудал. Тэгээд тэр бид нар цахим болгож байгаа, ил тод болгож байгаа тэр бүлгүүдийнхээ хүрээнд Засгийн газрын жагсаалтаар батлагдсан бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа зөвхөн нэг эх үүсвэрээс биш хэд хэдэн эх үүсвэрээс худалдаж авч болно, тэр нь одоо 1 жил хүртэл гэрээ хийдэг байсныг 3 жил хүртэл хийж болно оо гэсэн ийм зохицуулалтыг хийж өгч байгаа.

Баделхан гишүүн асуулт асууя.

Х.Баделхан: Баярлалаа.

Тэгэхээр энэ хуулийн төсөлд өмнө ч гэсэн тендерийн шалгаруулалтын хамгийн гол үзүүлэлт бол үнэ хамгийн бага үнэ гэсэн байсан шүү дээ. Энэ яг энэ төслөөр бас яг тийм байгаа юм. Энэ үнэ гэдэг бол бага үнэ гэдэг бол эерэг, сөрөг талтай. Сайн тал нь төсөв хэмнэж байгаа, муу тал нь бол хамгийн чанаргүй л ажил хийгдэж байгаа, нэгдүгээр асуулт.

Хоёр дахь нь бол ингээд тендер шалгаруулахдаа бол ерөөсөө бүрдүүлсэн материалаар сайн шалгаруулж байгаа шүү дээ. Бүрдүүлсэн материалаар тэгээд сайн байвал шалгараад гэтэл жинхэнэ амьдрал дээр бол нөгөө тэр ажиллах хүчин, тэр техник хэрэгсэл нь бол байхгүй. Эндээс болоод нөгөө цүнхний компани гэсэн нэр гарсан шүү дээ. Тэгэхээр бүгдийг нь цахимжуулчихаж байгаа юм байна. Энэ бол сайн хэрэг. Хүн оролцохгүй. Гэхдээ яг амьдрал дээр тэр тийм юм байгаа юу? Тэр ажиллах хүчин хийх боломж нь байгаа, үгүй юу гэдгийг нь ер нь яг шалгах ямар боломж байдаг юм бол? Энэ бол хэцүү шүү дээ. Ер нь энийг яаж тодруулах вэ гэсэн 2 дахь асуулт байна.

3 дахь нь бол сая гадаадын компани гэж хэллээ. Жавхлан сайд 30 тэрбумаас дээш бол гадаадын компанид орж болно л гэж ойлгож байгаа л даа. Гэхдээ гадаадын компани авчхаад, тэгээд өөрийн эрхгүй ер нь дотоодын компани аваад л ажил хийлгэчихэж байгаа юм бол байгаа. Тухайлбал, манай аймагт бол зам байгаа. Бид нар яг мэдэж байгаа. Энэ Дарханы зам ч гэсэн тийм маргаан байгаа. Тэгэхээр аль болохоор бид нар дотоодын компаниа л дэмжмээр байна л даа. Ер нь дотоодын компаниа дэмжээд бид нар дотоодоо бэхжүүлэхгүй бол энэ гаднын компанийг заавал нэг тийм оруулж байх шаардлага байгаа байгаа юм уу? Ер нь зүгээр онцгой, технологийн шаардлага хийж чадахгүй гэсэн ажил дээрээ л бол ер нь тэр тендерийн

нөхцөлөөрөө л гадаад, дотоодыг ялгаж өгөөд тэрнээс биш голдуу дотоодын компаниа дэмжээд явчихвал зүгээр юм биш үү гэсэн санал байна. Тэгээд нөгөө гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгаа гэдэг нь бүгд хуучнаараа юу? 5 сард шинэчилснээрээ тийм ээ.

Тэгээд хамгийн гол нь тэр ажлын дадлагатай, туршлагатай хийх чадалтай яг бодит компаниа л бид нар шалгаруулбал энэ бол үр дүнгээ өгнө л дөө. Дунд нь нэг хүн орж ирээд ерөөсөө цаасан дээр бол бүх юм гоё. Гэтэл амьдрал дээр тийм биш байвал энэ л ер нь амьдрал дээр бас ер нь хэцүү болж байгаа шүү дээ. Энийг яаж ялгаж салгах вэ гэсэн ийм асуулт байна.

Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг хариулъя. Нэг номер Батзул.

Ц.Батзул: Баделхан гишүүний асуултад хариулъя.

Ажлын хэсгийн гишүүн Батзул. Таны ярьж байгаа асуудлын хүрээнд бол бид нар компанийн ААН-ийн бүртгэлийг нь сүүлийн 2 жилд бол манай Монгол Улсын төрөөс хөтөлж байгаа мэдээллийн системд байгаа өгөгдлүүд бол харьцангуй цэгцтэй, бас хоорондоо цахимаар солилцох боломж нь бол үнэхээр сайн хөгжиж байгаа. И баримт мөн энэ хур систем и монголиатай холбогдоод тендерийн систем бол нийт 17 орчим бусад мэдээллийн систем мэдээллийг нь татаж байгаа. Жишээ нь тендерийн баталгаа арилжааны банкнаас татаж байна. мөн санхүүгийн тайлан, ажиллах хүчний нийгмийн даатгал төлөлт мөн тухайн ажиллах хүчний ажил инженер техникийн ажилтан, дипломын мэдээлэл мөн тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа машин механизм, бүх мэдээллүүдийг нь бол бодит цагийн горимоор яг энэ компани дээр бүртгэлтэй байна уу гэдгийг нь татаж аваад тэр лавлагаан дээрээ үндэслээд үнэлгээ хийж байгаа. Энийгээ бид бүр илүү сайжруулаад аль болох тендерт оролцогчоос ийм илүү дутуу мэдээлэл авахаа больчихъё. Одоо жишээ нь төрд бол бид нар судалгаа хийхээр нийт тендер нэрээр 200 хуудас материал сканердаад явуулж байгаагийн 180 хуудас нь бол төрийн аль нэг байгууллагад нь заавал байж байгаа.

Тэгээд энэ мэдээллийн системийн холболтыг нь сайжруулаад, ерөөсөө төрийн байгууллага, тендер нэрээр ААН-ийг нэг байгууллагаас нөгөө байгууллага руу явуулаад лавлагаа, цаас, сканердуулж явуулдаг энэ харилцаагаа больчихъё, зөвхөн тухайн мэдээллийн системээс нь шууд төр өөрөө ороод авчихъя. Харин бусад хууль тогтоомжийн хүрээнд ААН-ээс нь зөвхөн зөвшөөрөл авна. Та миний мэдээллийг энэ тендертэй холбоотойгоор ийм ийм агуулгыг лавлах эрхтэй болно. Ийм хугацааны хооронд гэдэг зөвшөөрлийг нь аваад, тэгээд тэр зөвшөөрөл дээрээ үндэслээд лавлагаануудыг нь татаад үнэхээр энэ хүн хүчин чадалтай юм уу? Нөөц бололцоотой юм уу гэдэг лавлагаан дээрээ үндэслээд явж байна гэсэн үг.

Тэгэхээр яг энэ агуулгаараа гэх юм бол үнэлгээний хороо 200 нүүр хуудас материал үзэж байж шийдвэр гаргадаг байсан бол энийг нь 180 хуудсаар багасгачихаар ерөнхийдөө хүний оролцоо бараг 10 дахин буурах боломжийг нь нээж өгч байгаа юм. Тэгээд дээрээс нь энэ дээр нэмээд нөгөө хуурамч материал бэлддэг, өөрсдөө засдаг энэ асуудал маань шууд мэдээллийнхээ эх үүсвэрээс нь авчаж байгаа учраас арилна. Дахиад тендер нэрээр нотариатаас мөнгө нотариатын

баталгаа шаарддаг байсан энэ юмнууд дунд тэгээд төрийн байгууллагаас энэ ажлыг үнэхээр энэ компани хийсэн юм уу, хийгээгүй юм уу гэдэг хэрэгтэй, хэрэггүй цаас цуглуулдаг ажлуудаа ерөөсөө болиод тэгээд төр, төртэйгөө харьцдаг ийм цахим систем хөгжүүлээд явъя гэж байгаа юм.

Мөн тендерийн систем дээр байгаа бүх мэдээллүүдийг машин унших боломжтой, өгөгдөл хэлбэрээр хадгалаад бусад бүх мэдээллийн системтэй харилцан солилцдог байхаар бас хуулийн төсөлдөө тусгачихсан байгаа.

Тэгэхээр А компани улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 газар, 3 байшин барьж байгаа бол тэрний санхүүжилт нь хэдэн хувьтай явж байгаа юм. Одоо дахиад нэмээд ажил өгөхөд нийт ажилчид нь хүрэх юм уу, машин механизм хүрч байгаа юм уу гэдэг нь дээр нь анализ хийгээд дараагийн шийдвэрээ гаргах боломжийг нь бол хуулиар зааж өгч байгаа юу. Гадаадын этгээд орох асуудал дээр гэхээр бас Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцоор бид нар тарифын бус зохицуулалтыг бас хамаагүй хийхэд хүндрэлтэй асуудлын хүрээнд бол яг энэ байгаа босгоо ханшийн тарифын хүрээнд нэмэгдүүлээд явж байгаа. Үнэ биш хуулийн бас нэг шинэлэг зохицуулалт нь юу вэ гэхээр шаардлагад нийцсэн компаниуд санал болгож байгаа бараа үйлчилгээ нь стандартыг хангасан гэж үзэж байгаа бол үнээр нь эрэмбэлээд багыг нь үздэг. Тэгэхээс шаардлага хангаагүй компаниас шууд татгалзаж байгаа. Энэ харилцаа нь яг хэвээрээ явна.

Дээрээс нь бид нар 80 хувиас доош үнийн санал, үндэслэлгүйгээр үнийн санал ирүүлэх юм бол тендерээс нь татгалзахаар шинээр оруулж ирж байгаа.

Дараагийн сонголтыг нь болохоор бид нар ашиглалтын хугацаа.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тодорхой цаг үеийг туулсан, сайжруулах, боловсронгуй болгох юмнууд бидэнд их тодорхой л харагдсан л даа. Тийм учраас би энэ хуулийг овоо энэ цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж үзэл баримтлалынх нь хувьд сайжруулсан байх гэж бодож байна. Ерөнхийдөө уншсан. Зүгээр хэд хэдэн зүйл тодруулах ёстой юм байна гэж ингэж хараад байгаа юм. Өнөөдрийн явж байгаа үйл явц дотор чинь тэр улсын нууцад авсан үйл явцуудаас ч хамааралтай асуудал үүсээд болж өгөхгүй байгаа юм. Гэтэл энэний 3.1.1 дээр ч билүү заачихсан байна лээ. Улсын нууцад хамаарсан зүйлд энэ хууль үйлчлэхгүй гээд. Тэгээд тэрийгээ ер нь юу гэж ойлгож байна вэ? Тэрийг багасгах тухай асуудал хэдүүлээ ярих ёстой гэж ойлгосон. Ер нь худалдан авах ажиллагаа том төслүүдэд саад болоод болж өгөхгүй байна. Хялбаршуулсан байдлаар бараг шууд гэрээ хийгээд явчихдаг хэлбэр рүү оръё гэж ноднин орж ирээд асуудлыг хэдүүлээ хойшлуулсан шиг санаад байна би Их Хурал дээр. Энэ чиглэлийн харилцааг яаж зохицуулав гэдэг асуудал.

Хоёр дахь зүйл зүгээр Төсвийн хууль руу бол бид нар оруулъя гээд төсөв батлахдаа нэг зүйл хийсэн. Тэр нь бол төсөв нь сүүлийн 2 жил дотор багтаж магадлал хийлгэгчихсэн байх ёстой. Ингэж байж энэ төсөвт сууна. Тэгээд цаашаа тэр

худалдан авах ажиллагаа нь зарлагдаж явна гэдэг энэ зарчим явсан. Тэгэхээр энэ дотор энэ чиглэлийн юм яаж оров гэдэг асуудал байна.

Дээр нь бид нарын өнөөдөр энэ гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагааныхаа эрх зүйн зохицуулалт дотор арай дутуу тусгаад яваад байгаа юм болов уу гэж хараад байдаг юм. Зураг төсөв боловсруулахдаа ямар материалаар, ямар стандарттай, юугаар хийх вэ гэдэг юмыг бараг дээд үнээр нь шахуу авч хийчхээд гүйцэтгэгч сонгон шалгаруулахдаа бид нар бараг хамгийн бага үнийн саналыг нь авчихдаг учраас энэ ажлын чинь чанар, эдэлгээний хугацаа муудаад болж өгөхгүй байгаа юм.

Тийм учраас 0.5 миллиметртэй төмрөөр хийнэ л гэсэн бол яг л тэрүүгээр нь хийлгэдэг юмыг энэ хууль дотор нэлээн тодорхой болгож оруулж өгөхгүй бол тэр тендерийн материалын бүрэлдэхүүн хэсэг дотор их тодорхой оруулж өгөхгүй бол энэнээс чинь болоод энэ ажлын чинь чанар, эдэлгээний хугацаа, үр өгөөж муудаад болж өгөхгүй байгаад байгаа юм бий энийг та хэд юу гэж харж оруулав гэдэг асуудал байна.

Дараагийн нэг асуудал байгаад байгаа юм. Энэ орон нутгууд өөрийнхөө ААН-үүдийг дэмждэг нэг тийм үйл явц байдаг юм. Би тэрийг буруу ч гэж боддоггүй.

Нэгдүгээрт, орон нутгийн эдийн засгийн өсөлт байдаг.

Хоёрдугаарт ажлын байр хангалттай байдаг.

Гурав дугаарт төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэмэгддэг.

Дөрөвдүгээрт, буух эзэнтэй, буцах хаягтай байгаад байдаг байхгүй юу. Гэтэл одоо энэ хуулийг уншихаар зэрэг бол орон нутгийн ААН-үүдээ дэмжих үйл явц бол тийм төдийлөн тусаж орж чадаагүй юм байна лээ. Тэрнийг бид нар авдаг юм нь юу байсан бэ гэхээр зэрэг ажиллах хүчнийх нь тооноос хамааруулаад үндсэндээ нийт ажилчдынх нь 30 хувь ч гэдэг юм уу, 50 хувь нь ч гэдэг юм уу, орон нутгаасаа байх юм бол тэрэнд давуу эрхийг нь хийсвэр гэдэг биз дээ бид нар давуу эрх олгоод үнийн дүнгээс нь бууруулчихдаг энэ заалт явсан, байхгүй болчихсон байна. Энийг ер нь юу гэж үзээд та нар авчих ваа гэдэг нэг ийм зүйл гарч ирээд байгаа юм.

Дараагийн нэг асуумаар байгаа зүйл яах вэ бид ингээд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаад явж болдог юм байж. Хамгийн гол зүйл бидэнд захиалагчийн хийгээд ашиглагчийн хяналтын тухай асуудал байгаад байгаа юм. Тэрүүнийг ер нь ямар харилцаагаар яаж зохицуулаад байна вэ? Тэр тусмаа тэр барилга байгууламж дээр тэр талбайн хяналтын асуудлыг ер нь юу гэж тусгаж оруулав аа? Ерөөсөө бид нарын энэ сүүлийн он жилүүдэд орхигдуулсан нэг их том алдаа бол энэ захиалагчийн хийгээд гүйцэтгэлийн хяналтыг тавих ерөнхий эрх зүйн зохицуулалт дутуу байсантай холбогдуулаад энэ барилга байгууламж юмнуудыг чинь үе шатны ажил болгон дээр акт үйлдэгддэг өдөр болгон тэр дэвтэр дээр журнал хөтлөлт хийгддэг юм эд нар чинь орхигдсоноос болоод чанар юмнууд муудаад болж өгөхгүй байгаад байсан юм. Энийг энэ хуульд яаж засаж залруулж, зөв зохицуулалт хийж оруулж ирэв ээ? Энүүн дээр нэг тов тодорхой тайлбар авмаар байна. Тэр нэг үнийн босготой юм байгаад байгаа

юм аа. Ажил болохоор 30 тэрбум, бараа болохоор 1 тэрбум, үйлчилгээ болохоор 300 сая билүү дээ.

Тэгэхээр энэнээс давсан хэсэг дээр нь бол гаднын компани, хуулийн этгээд орж болохоор нэг тийм заалт орж ирчхээд байна л даа. Тэгээд одоо .

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг Батзул уу? Жавхлан сайд. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Сүүлийн асуултаас нь эхэлье. Тэр 30 тэрбум, 1 тэрбум 300 гэж байгаа чинь одоо байгаа босгыг нь харин өндөр болгож байгаа юм шүү эсрэгээрээ. Тэр 30 тэрбум болж байгаа тэр хязгаар босго маань 10 тэрбум байгаа юм. Одооныхоо хуулиараа. Таны хэлж байгаа 1 тэрбум чинь одоогийнхоо босгоороо 100 сая байгаа юм. Зуун саяас дээш бол энэ чинь нэг тэрбум биш, зуун саяас дээш л бол гаднын компаниуд орж болох ийм заалттай байгаа байхгүй юу. Тэрийг нь босгыг нь өндөр болгож, дотоодын компаниудаа оруулах боломжийг нь нэмж байгаа гэсэн үг. Тэр захиалагч хянагчийн хоорондын харилцааны зохицуулалтыг ажлын хэсгээс хариулчхаарай.

Тэр нууцын асуудал бол Батжаргал гишүүн ээ ийм байгаа шүү. Энэ нэгэнт нууцын тухай хуулиар өөр хуулиар зохицуулагдаад явдаггүй учраас тэрэнтэй уялдаж өмнө байсан заалт яг хэвээр хадгалагдаж байгаа гэсэн үг. Харин хавар бид нэмэлт, өөрчлөлт оруулж ирж байхад, сая яг таны хэлсэнчлэн тэр шууд гэрээнүүдийн, ялангуяа томоохон бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтууд дээр хугацаа алдахгүй байх түргэн шуурхай хийх, тэгээд бид нар энэ сонгуулийн жил чинь хэдэн жил билээ? Энэ үр дүнг нь бид үзэх ийм зорилготой заалтууд орж ирж байсан боловч бүлэг дээр дэм энэ дээрээ сайн дэмжлэг яваагүй. Тэгээд Их Хурал руу оруулаагүй хассан шүү дээ. Тэгэхээр яг тэр чигээрээ л явж байгаа. Хассан хэвээрээ. Тэгэхээр нэмэлт шууд гэрээний зохицуулалт бол байхгүй шүү. Харин одоо хууль дээр байгаа шууд гэрээний зохицуулалтуудыг илүү ил тод тодорхой болгосон байгаа. Эрсдэлийг нь бууруулж. Тэнд тодорхойгүй юм маш олон юмнууд байсныг нь маш тодорхой болгож ингэж оруулж ирж байгаа гэсэн үг. Тэр магадлалыг 2 жилийн дотор гэж байгаа заалт мөн энэ хуульд ч байгаа. Мөн бид нөгөө Төрийн хэмнэлтийн хууль дотроо ч энийгээ маш нарийн оруулчихсан. Маш сайн зохицуулалттай болсон. 2-оос дээш жилээс өмнө хийгдсэн магадлан болон тэр үнийн зохицуулалтаар бол бид төсөвт суулгахгүй.

Худалдан авах ажиллагаа нь хийгдэхгүй, төсөвт суулгахгүй учраас ийм байгаа. Тэгэхээр ер нь бол худалдаах ажиллагаа эхлэхээс өмнө хийгдчихсэн байх ёстой процесс гэж ойлгоорой. Бага үнээр гэдгийг бол түрүүн Батзул бас хариуллаа.

80 хувиас доош ийм үнэ орж ирвэл тендерийн хорооноос татгалзах хэрэгцээ. Дээрээс нь хэрвээ наyas үнэ орж ирлээ гэхэд ашиглалтын жилүүддээ дараа жилүүддээ ашиглах өртгүүд нь энэ үнээсээ давсан. 100 төгрөгийн худалдан авалт хийчхээд жил болгон зуун төгрөгийн өртөгтэй ашиглалтын зардал гардаг бол мөн үүнээс татгалзах ийм боломжуудыг хуульд нь нэмж шинээр ийм зохицуулалтуудыг оруулж өгсөн. Орон нутгийн ААН-үүдийг дэмжих тэр захиалагч, хянагч хоёрын харилцааг ажлын хэсгээс хариулчих даа.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг 2 номер.

3.Энхболд: Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ зураг төсөл боловсруулах болон энэ захиалагчийн талбайн хяналт гэсэн 2 асуулттай холбогдуулж хариулт хэлье.

Яг барилгын талбай дээр захиалагчийн тэр захиалагчийн инженер, барилгын норм, дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг бол Барилгын тухай хуулиар зохицуулсан байгаа. Барилгын тухай хуулийг дагаж гарсан маш олон дүрэм журам, стандарт бол нормчлол бол байдаг. Энэ нь бол холбогдох барилгын хуулиар бол зохицуулагдаад явах юм. Харин тэр зураг төсөл боловсруулахдаа өндөр үнэтэй чанартай материалаар төсөвлөж орж ирчхээд яг гүйцэтгэл дээрээ болох тэр чанар муутай бараа материал авч хэрэглээд байна гэж байгаа юм. Яг тендерт оролцохдоо өгч байгаа тэр зураг төсөв болон ажлын зураг төсөв нь бол гэрээний яг хавсралт болоод гэрээний нэг бүрэлдэхүүн хэсэг болдог байгаа. Тэгэхээр гэрээний хэрэгжилт дээр хяналт тавьж байгаа захиалагч болон захиалагчийн хяналтын инженер, мэргэжлийн хяналт, барилгын хөгжлийн төв гээд олон байгууллага бол хяналт тавьж байгаа.

Тэгэхээр энэ хяналт тавьж байгаа Байгууллагууд маань хяналтаа сайжруулаад явах юм бол энэ бол шийдэгдээд явах бүрэн бололцоотой асуудал байгаа. Энэ нь бол тухайн барилгын салбарын маш том хуулиар маш олон дүрэм журам заавар бол байдаг. Мөн хуулиар нь бол Зөрчлийн болон Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх хариуцлагын зохицуулалт нь бас тухайн салбарын хууль дээр байж байгаа.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг нэгдүгээр микрофон нэмж тайлбар өгье.

Ц.Батзул: Батжаргал гишүүний асуултад хариулъя Батзул.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлд нь дотоодын үйлдвэрлэлийг дэмжих давуу эрх тооцох бүлэг зохицуулалтыг нь оруулсан байгаа. Одоогийн хуульд мөрдөж байгаа давуу эрх олгох зохицуулалтууд мөн хадгалагдаж байгаа. Орон нутгийн ажиллах хүч авахаар санал болгосон ААН 7.5 хувийн хөнгөлөлтийг үзүүлнэ. Дээрээс нь нэмээд нийслэл, дүүрэг, улсын зэрэглэлтэй хотод хамаарахгүй тухайн орон нутагт сүүлийн 2-оос доошгүй жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулж ажлын байр бий болгосон бол тендерийн үнэд нь бас 5 хувийн нэмэлтээр давуу эрх олгохоор онд шинэ зохицуулалт оруулж ирсэн. Тэгээд яг одоогийн давуу эрхийн зохицуулалтыг нь бол яг хэвээр нь хадгалаад явж байгаа, нэмэлтээр мөн орон нутагтаа үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд бол ийм зохицуулалтыг шинээр нэмж оруулсан байгаа.

Тэгэхээр таны түрүүний асуусан орон нутгийн компаниуд давуу эрх олгодог зохицуулалт бол яг хэвээр үргэлжлээд явна гэж ойлгож болно.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Батжаргал: Яг наад заалтаа хэдүүлээ нэг жаахан тодруулмаар байгаа юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 25-аас дээш ажилчин энэ тэр гэсэн нэг ийм үгээр орчхоод байгаа байхгүй юу. Тийм учраас яг орон нутгийн иргэдээс тэд эд гэсэн юм

бол энэ хуулийн одоо байж байгаа төсөл дээрээс бол би олж уншихгүй байгаа юм. Ний нуугүй үнэнийг хэлэхэд. Тэгэхээр хэлэлцүүлгийн явцад нь хэдүүлээ энийг анзаарах ёстой. Энэ орон нутгуудад энэ аж ахуйнуудыг бойжуулах, тэгж байж энэ орон нутгийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх, төсвийн бүрдлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хангах цаанаа ихээхэн том үр нөлөөтэй үйл явц байхгүй юу. Энийг бид нэлээн сайн анхаарч, энэ хууль дотор тусгаж оруулах ёстой гэдэг талаас нь бол би зориуд хэлмээр санагдаад байгаа юм гэж.

Барилгын хуулиар зохицуулж байгаа харилцаанууд байгаа байх. Гэхдээ хэдүүлээ нэгэнт гүйцэтгэгч сонгон шалгаруулчхаад байгаа бол түүнтэй байгуулах гэрээн дотор ийм ийм зүйлд тусна гэж нэгэнт хэлж чадаж байгаа бол тэр нь дотроо яг саяын хэлээд байгаа зүйлүүдийг оруулчихмаар байгаа юм. Тэгж байж хяналт тавихгүй бол наадах чинь орхигдчихоод бид хэдийн ер нь туулсан орон нутгийн энэ хийгдээд байгаа гэдэг юм уу, ер нь хийгдээд байгаа хөрөнгө оруулалтуудын чанар юманд чинь доголдол үүсгээд байгаа юм ерөөсөө л энэнтэй холбоотой зүйл ээ.

Тийм учраас энүүнийг хэдүүлээ энэ гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнийх нь асуудал тал дээр нэлээн нарийн тусгаж оруулах ёстой. Гэхдээ өнөөдөр зөвхөн аймаг дээр Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар наад захиалагчийн чинь хяналтыг хэрэгжүүлж байгаа юм. 27 сумтай аймагт талбайн хяналт хийгээд мөнхийн сууж байдаг орон тоо тэнд байхгүй ээ.

Тэгэхээр зэрэг тухайн орон нутгаас ашиглагчийн тодорхой ажлын хэсэг байгуулаад 2, 3 хүнтэй тэрийг мэргэжлийн зөвлөмж чиглэлээр нь хангаад өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавиулаад, дэвтэр дээр нь юм бичүүлээд, тодорхой графикаар очихдоо өнөөхийг нь үзээд зөв бурууг нь цэгнээд явдаг ийм үйл явц эд нарыг бид энэ олон нийтийн оролцоо.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг Жавхлан сайд.

Б.Жавхлан: Энэ удаагийн нэм шинэчилсэн найруулгаар бид нар тэр эх оронч худалдан авалтыг дэмжих, Засгийн газрын зорилтод нийцүүлэх гэж бас нэлээн хичээсэн юм. Тэгэхээр саяын Батжаргал гишүүний хөнддөг асуудлыг хэлэлцэх явцдаа Батжаргал гишүүн болж өглөөд өөрөө яг ороод томъёолоод ингээд ярилцаад явбал яасан юм бэ? Одоо бол хэдүүлээ зөвхөн яг бас яг энэ хүрээнд дэмжээд л болчих асуудал бас биш шүү дээ тийм ээ. Өөр олон ч асуудлууд бас байж болох нөхцөлүүд байгаа.

Тэгэхээр энэ асуудлаа энд орхиод би хэлэлцэх явцдаа яриад явъя гэсэн саналтай байна.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүн асуулт асууя.

Д.Өнөрболор: Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга орж ирж байна. Ер нь иргэдтэй уулзалт хийгээд явахаар ер нь иргэд энэ ААН-үүд бол ихээхэн шүүмжилдэг хуулийн нэг юм аа. Энэ хууль бол. Тэгээд л бага үнийн аргаар нэрээр төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байна. Авлига ашиг сонирхлыг өдөөж байна.

Тендерийн шалгаруулалт явагдаж байна гээд бүтэн жил тойрдог, тэгээд тэрийгээ хэрэгждэггүй, албан тушаалтнуудын хариуцлагагүй асуудал энэ тэр гээд. Энэ дээр бол маш их, олон сул талууд байдаг. Тэгээд энэ дээрээс нь сая одоогийн энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан энэ яаралтай гэдгээр шууд худалдан авалт хийдэг. Энэ шууд худалдан авалттай холбоотой гомдол хүсэлт бас их байдаг. Тэгээд энэ Сангийн яамны энэ яаралтай тэгээд энэ шууд амбицыг бол Улсын Их Хурлын гишүүд бид бол дийлэхгүй юм байна лээ.

Үндсэндээ энэ худалдан авалттай холбоотой, яг шууд худалдан авалт хийх ач холбогдлыг нь би бол үнэхээр ойлгохгүй байгаа. Миний өмнөх ч гэсэн маш их олон гишүүд асууж байна шүү дээ энэ асуудлыг. Тэгээд ерөөсөө ч ойлгохгүй байгаа юм.

Сангийн яамны Жавхлан сайдын хэлж байгаагаар бол ер нь зөвхөн ААН-үүдэд л ер нь хар данс нээж байгаа л гэсэн асуудал яриад байгаа юм. Би бол ойлгохдоо бол ер нь энэ худалдан авах ажиллагааг нь төлөвлөх, хэрэгжүүлэх тийм ээ энэ тайлангууд процесс өөрөө нээлттэй биш. Албан тушаалтны хариуцлагагүй байдлаас болж энэ хулгай дээрэм их гардаг юм байна. Үүнээс нь ард иргэд, ААН-үүд бол маш их хохирдог юм байна гэсэн ийм л ойлголттой байгаа юм миний хувьд. Тухайлах юм бол энэ Эрдэнэс Тавантолгой компанийн хийсэн аудитыг би бас үзэж уншлаа. Энэ дээр бол маш их шаардлагагүй, ашиглагддаггүй өндөр өртөгтэй, их хэмжээний үхмэл хөрөнгийг бол худалдан авалт хийсэн байх юм.

Нөгөөтээгүүр энэ компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилт нь 34-хөн хувьтай байна аа. Тэгсэн чинь худалдан авсан бараа, ажил үйлчилгээний зардал нь бол 7.5 их наяд байх юм аа. Тэгээд энэ 2 тоог л зөвхөн харьцуулаад ингээд аваад үзэхлээр энэ менежмент удирдлагын тогтолцооны асуудал үнэхээр алдагдчихсан юм байна аа. Маш том эрсдэлд орчихсон юм байна гэдэг асуудлыг Жавхлан сайд та юу гэж тайлбарлах вэ?

Нөгөөтээгүүр гээд тэгэхэд энэ концесс, тэгээд л энэ худалдан авалт, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль энэ тэр гээд л тэгэхээр Сангийн яам нэг их ингээд л мэдлэгтэй, нэг их ингээд л туршлагатай гээд л, нэг их чадвартай гээд л ингээд л ороод л ирдэг. Тэгээд л энэ хуулийн боловсруулж байгаа энэ төсөл хөтөлбөрүүд нь бол ямар ч тийм эргээд хөрсөн дээрээ буусан, амьдралгүй ийм хуулиуд боловсруулдаг. Тэгсэн хэрнээ тэрийгээ гоё тайлбарладаг. Үр дүн, хариуцлага гээд тэгэхлээр бол тэндээс дандаа бултдаг энэ байдлуудаа ер нь хумих цаг болсон юм биш үү гэж би бодож байна. Тэгээд дээрээс нь энэ ТӨК-уудын энэ албан тушаалтнууд сахилга хариуцлагыг ер нь нэмэгдүүлсэн ер нь ямар зохицуулалтууд байгаа юм бэ? Энэ хуульд чинь. Тэгээд олон нийтийн хяналтыг ер нь хэрхэн хангахаар зохицуулалт хийсэн юм бэ?

Ер нь энэ ил байгаа худалдан авах ажиллагааны систем, тэгээд шилэн данс, мэдээлэл хоорондоо зөрдөг. Бодит мэдээлэлгүй энэ 2 хоорондоо бол ингээд маш зөрүүтэй байгаа. Ягаад энэ төрийн худалдан авалтын эрсдэлийг даатгах тогтолцоог олон улсын жишгээр түгээмэл ингээд ашиглаж болдоггүй юм бэ? Нэн ялангуяа энэ төрийн өмчийг үнэгүйдүүлэх, хамгаалах тогтмол үнийн зардлыг нөхөн төлөх хариуцлагын системийг эрсдэлийг нэгтгэн зохицуулах эд нар гээд ийм олон арга хэрэгсэл хэлбэрийг ашиглаж болж байна шүү дээ?

Тэгээд яагаад энэ төрийн худалдан авалтын эрсдэлийг удирдах эрсдэлийг бууруулах нөгөө талаасаа энэ түргэн шуурхай чанартай төсвийн хөрөнгө оруулалт үр ашигтай зарцуулах, энэ байх шаардлагыг бол ер нь ингээд хангаад ингээд ажиллаад явж болдоггүй юм бэ?

Дараагийн нэг чухал асуудал бол би сая энэ.

Г.Тэмүүлэн: Жавхалан сайд хариулъя.

Б.Жавхлан: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Тэр хууль боловсруулах асуудлаас эхэлье. Өнөрболор гишүүн ээ та хуулийн өндөр мэдлэгтэй, боловсролтой, дадлага туршлагатай бол та Их Хурлын гишүүн хүн. Хууль боловсруулаад өргөн барих эрх чинь танд бүрэн нээлттэй, бүрэн нээлттэй. Ганц байгууллагыг шүүмжлээд байх биш, та өөрөө энэ боломж ард түмнээс олгосон энэ эрхээ эдлэх нь таны бүрэн эрхийн асуудал шүү дээ. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг ярих гэж байгаа бол та өөрөө ажлын хэсэг байгуулаад хууль боловсруулаад өргөн барих үүрэгтэй ажиллаж байсан хүн шүү. Таны хуулийг хүлээсэн бол хүртэл батлагдахгүй байгаа байсан. Би ч бас ярих эрхтэй. Сонсож сур за юу. Чи сонсож сур.

Хар дансны асуудал. Хар дансанд оруулдаг зохицуулалт энэ хуульд одоогийнхоор ч байгаа. Цааш нь харин илүү их, шаардлага тавьж байгаа. Өмнө нь бол зөвхөн компанийн нэрээр нь ордоггүй байсан бол компанийн гүйцэтгэх удирдлага, хувь нийлүүлэгч нарын түвшинд бүр илүү их мэдээллээр ингэж оруулж байгаа. Цаашдаа ч энийгээ нэлээн бид нар чанга баримтлаад явна аа. Энэ хууль маань өөрөө төрийн болон орон нутгийн өмчөөр бараа материал, үйлчилгээ худалдаж авах тухай хууль төрийн болон төрийн өмчийн оролцоотой энэ компанийн засаглалын тэрэнтэй холбоотой асуудлыг бол өөр хуулиар зохицуулаад явна. Манайхан тэр юуг нь статистик хэлээдхээрэй. Маргаан шийдвэрлэдэг энэ зохицуулалт Засгийн газрын тухай хуулиараа энэ бараа үйлчилгээ худалдан авах энэ бодлого нь өөрөө Сангийн яаман дээр байсаар ирсэн. Энэ ч үүднээс урьдчилан шийдвэрлэх, маргаан таслах энэ процесс нь Сангийн яаман дээр явагддаг. Энэнтэйгээ хэрвээ 2 тал нь хүлээн зөвшөөрөхгүй бол шүүх рүү очих, шүүх рүү хандах энэ асуудал нь нээлттэй байдаг.

Энэ дээр статистикийн хэрэгтэй. Түрүүн нэг юм дутуу хэлсэн шүү. Нийт тендерийн 3 хувь нь болж буурч ирсэн байгаа, маргаан үүсдэг. Тэрнээс хэд нь энэ урьдчилсан шатандаа шийдэгдээд хэдэн цаашаагаа шүүх рүү очдог энэ тоог бас хэлэх хэрэгтэй шүү. Энэ тоонууд бол улам багассаар ирж байгаа. Өөрөөр хэлбэл тендерийн хуулийн өөрийнх нь хэрэгжилт, хэрэгжилтэд хяналт тавих, маргаан таслах, энэ процессууд бол нэлээн тийм боловсронгуй болж ирж байгаа гэсэн үг. Олон нийтийн тэр хяналт тавих, тендер шарлуулах процесс үнэлгээний хороонд оруулсан тэр олон нийтийн хяналт тавих нэмэлт заалтуудыг ажлын хэсгээс нь нэмээд хариулчих юм.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг нэгдүгээр микрофон Батзул.

Ц.Батзул: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн гишүүн Батзул.

Олон нийтийн оролцооны талаар хуулийн үнэлгээний хороо хэсэгт нь бол Үнэлгээний хорооны хоёроос доошгүй гишүүн нь заавал хөндлөнгийн төлөөлөл байхаар бол хуулийн заалт одоо ч байгаа. Энийгээ хадгалаад явж байгаа. Мөн захиалагч эрээ хүсэх юм бол үнэлгээний хороог нь нээлтээс өмнө дахин шинээр зохион байгуулах боломжийг нь хуулиар нээж өгч байгаа. Тэгэхгүй бол өмнө нь зарласан Үнэлгээний хороо нь тэр чигээрээ явсаар байгаад гэрээ байгуулдаг байсан бол энэ дээр бас асуудал байна гэж үзсэн учраас зарласан үнэлгээний хороог нь бүхэлд нь шинэчлээд, цоо шинэ үнэлгээний хорооны хүмүүсээр томилох боломжийг нь олгож байгаа.

Хоёрдугаарт нь бүх байгуулсан гэрээг нь олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ. Мөн бусад санхүүжилтийн болон төлбөрийн системтэй гүйцэтгэлийг нь уялдуулаад ямар их байгуулсан гэрээний гүйцэтгэл хэдэн хувьтай явж байгааг нь олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ. Энэ асуудал нь миний амьдарч байгаа эргэн тойронд явж байгаа төсөл хөтөлбөрүүд маань муу явж байна гэх юм бол энэ талаар бас санал хүсэлт, хэлэх эрхийг нь бол олон нийт иргэдэд олгож байгаа. Мөн гомдол шалгараагүй оролцогч нь шалгарсан компанийнхаа тендерийн материалтай бол танилцаж байгаа. Энэ зохицуулалтыг мөн хэвээр авч явна.

Дээрээс нь захиалагч байгууллагаас гаргасан үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, захиалагчийн шийдвэр, үнэлгээний хорооны шийдвэрийг нь тухайн тендерт оролцсон бүх компаниуд нь нээлттэй байхаар хуулийн төсөлд тусгасан байгаа.

2019 онд орсон хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу Сангийн сайдын тушаалаар энэ шалгарсан компанийн материалыг нь бусад компаниудад үзүүлдэг болсноос хойш үндэслэлгүй гомдлын тоо бол бараг 6 дахин буурсан. Өмнө нь бол нийт тендер шалгаруулалтын 21 хувьд нь гомдол гаргадаг байсан бол 4, 3 хувьтай болж буурсан байгаа. Нөгөө талдаа компанийн шүүх рүү очиж байгаа нь бол өнгөрсөн 2020 онд бол нийт улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 20 төсөл арга хэмжээтэй маргаан очсон. 2021 онд бол 16, энэ онд бол 3 захиргааны хэргийн маргаан үүсчихсэн. Нийт бол нэг хүрэхгүй хувь нь бол шүүх дээр маргаантай явж байгаа асуудал байна.

Тэгээд энэ оны хувьд бол нийтдээ энэ 26000 орчим тендер шалгаруулалт зарласнаас Сангийн яаманд бол 934 гомдол хянасан байгаа. Энэ нь болохоор нийт тендер шалгаруулалтын бол 3 хувьтай байгаа. Нийт гаргасан гомдлын 82 хувь нь үндэслэлтэй буюу 766 гомдлыг нь хянаж үзээд тендерт оролцогчийн зөв байна гэж шийдсэн байгаа юм. Тэгээд гомдол үндэслэлтэй байна гэж шийдвэрлэсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүн нэмж тодруулах уу? Микрофоныг өгье.

Д.Өнөрболор: Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүний хувиар би өөрийнхөө эрх үүргийг танаар заалгахгүй шүү, Жавхлан сайд аа.

Би маш сайн мэдэж байгаа.

Хоёрдугаарт гээд тэгэхэд би бол маш их олон зүйлийг ярьж байгаа шүү, таныг хурлын танхимаар ч гэсэн хэлсэн. Та Монгол Улсын хөгжлийг гацаасан маш их олон хуулийн боловсруулалтыг өнөөдөр оруулж ирж батлуулж байгаа шүү. Энэ бол цаг

хугацаанд бол харагдах байх гэж би бодож байна тэгээд сая тэр Сангийн яамны энэ тайлбарлаж хариулж байгаа асуудалд битгий ингэж та нар ингэж дөвийлгөж бай. Би маш тодорхой асуулт асуусан юм. Энэ Эрдэнэс Тавантолгой компанид тийм хийсэн аудитын тайлангаар 34 хувьтай байна аа. Энэ компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилт нь. Тэгэнгүүт худалдан авсан бараа, ажил үйлчилгээний зардал нь 7.5 их наяд байна аа тийм ээ. Тэгээд энэ 2 тоог ингээд харьцуулахаар ямар менежмент, удирдлагын тогтолцооны ийм эрсдэл үүсчихсэн байгаа нь эндээс харагдаж байна. Гэтэл энийг хянах байгууллага бол Сангийн яам өөрөө Сангийн яамны харьяа байгууллагууд шүү дээ гэж л би харин асуугаад байна шүү дээ. Тэгээд энэ дээр би хариултаа авчихмаар байх юм Жавхлан сайдаас.

Г.Тэмүүлэн: Жавхлант сайд тавиулъя.

Б.Жавхлан: Өнөрболор гишүүнээ наад тогтолцооныхоо асуудлыг сайн хараарай. Бид энэ чиглэл чиглэлийн яамдууд нь өөрсдөө хариуцаж хянадаг. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үйл ажиллагаанд өдөр тутмын үйл ажиллагаанд бид оролцож хяналт тавьдаггүй. Харин энэ төрийн өмчийн энэ Тендерийн хуулийн энэ бодлогын асуудлыг хэрэгжүүлдгийн хувьд энэ хууль дээр нь харин саяын таны хэлж байгаа энэ зөрчлүүдийг цааш нь гаргахгүй байх талаар хумих талаар энэ зохицуулалтуудыг нь хийж өгч байгаа юм. Ямар ч байсан Төсвийн хуулиар бараа материал худалдан авалт хийж байгаа бүх процессууд анхнаасаа эхлээд дуустлаа ил тод байгаа. Дундын санхүүжилтүүд нь яаж хийгдэж байна? Яаж хоцорч байна. Гүйцэтгэл нь ямар шатандаа явж байна? Аль албан бичиг нь бүр хэн дээр явж байна гэдэг нь ч хүртэл харагддаг ийм болсон байгаа. Энэ хуулиар энэ дээр нэмэх нь.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ нүүрсний хулгайнаас дутахааргүй энэ төрийн дунд болон анхан шатанд төрийн байгууллагууд дээр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдах буюу тендерийн хуулийг энэний цаана хулгай луйврууд асар их байгаа юм аа? Нүүрсний хулгайгаас дутахааргүй. Тэгээд энэ хуулийг маш сайн, олон нийтийн оролцоо, шилэн хяналттай байлгах асуудал бол Сангийн яамнаас оруулж ирж байгаа юм байна. Сая тайлбар хийсэн яамныхны албан тушаалтнуудын хэлж байгаагаар бол бас авах юмнууд их байна. Үнэхээр яг амьдрал дээр ийм болж байгаа бол сайн байна гэж хэрэгтэй хэрэггүй компаниудыг тэр олон зуун хуудас материал бүрдүүлдэг, энэнээс ангижирч байгаа юм байна. Төр өөртөө байгаа мэдээллүүдийг компаниудаас нэхэж, цаас болгож канондаж, тэрийг архивладаг ийм байдлаас салж байгаа юм байна гэж ойлголоо.

Энэ бол компаниудад маш амар хялбар байгаа байх. Нөгөө талаар цахим болж байгаа юм байна. Хүний оролцоог багасгаж байгаа юм байна аль болох. Хэд хэдэн зүйлийг л хүсээд байгаа энэ хуулиас. Энэ тендер чанаргүй боллоо, хийсэн гүйцэтгэсэн, авсан бараа бүтээгдэхүүнүүд чанаргүй байна гэдэг юм бол энэ үнийн дүнтэй л холбоотой. Хамгийн бага үнийн дүнгээр сонгон шалгаруулдаг, хийлгэдэг, худалдан авдаг асуудал. Нөгөө талаар энэ маргаантай асуудал байдаг. Тэгээд манайх тендерийн хугацаа, ажил үйлчилгээ хийхэд ямар хугацаанд хийдэг билээ. Жилийн 4 улирлын чинь зуны 3 сар, намрын 3 сар гээд л ингээд л 6 сард нь л хийдэг. Тэгээд нэг маргаан гарахаар үндсэндээ бараг сар болж байж ахиад тендер зарлах

хугацаа. Ахиад маргаан гардаг, ахиад сар хүлээнэ гээд ингээд үндсэндээ бараг нөгөө ажил үйлчилгээ хийх боломжтой хугацаа нь ингээд дуусаад үндсэндээ бараг энэ хугацаа чинь явж явж компаниудыг тэр ажил хийлгэх, чанаргүй ажил хийх тэр үндэс суурийг нь. Тэгээд заавал ингээд компани оролцохгүй эсвэл баахан маргаан болоод цаг хугацаа өнгөрөөд байх тусмаа нөгөө хугацаа багасаад ирэхээр онд шахагдаад төсөвтөө баригдаад ингээд чанаргүй ажил үйлчилгээ хийх суурь болоод байгаа. Энийг та бүхэн маань энэ Тендерийн хууль дээр, нөгөө талаас цүнхний компаниудыг тендерт оролцдог байдлыг яаж таслан зогсоохоор байна вэ энэ хуулиар. Бараг зар явж байгаа шүү дээ. Тендер авч өгнө, тэдэн хувийг нь яана энэ тэр гээд. Ийм байдлаар тэгээд дээгүүрээ тендер бараг сонгон шалгаруулалт нь тодорхой болчихсон ч юм шиг юм яриад явж байдаг.

Энийг цаашдаа яах гэж байна вэ? Тендер цахим болсноор нэг компани хэд хэдэн тендерт оролцож байгааг яаж мэдэх бололцоотой вэ? Хотод нэг тендер авчихдаг, сургууль, цэцэрлэгийн тендер, Хэнтий аймагт нэг тендер авчихдаг, Өмнөговьд нэг тендер авчихдаг, Ховдод нэг тендер авчихдаг.

Ингээд хүн хүч, техник хэрэгслийн хувьд төсөв санхүү, эдийн засгийн чадавхын хувьд ингээд энд тэнд саармагжаад, энд тэнд гурилдаад ажил хийгээд яваад байдаг. Энийг цаашдаа энэ цахим болсноор таслан зогсоох бололцоо, боломж байна уу, үгүй юу? Нөгөө талаар энэ санхүүжилтийн асуудал байгаа. Яамнаас зарласан зарим тендерүүдэд ажил нь хийгдээгүй байхад яамнаас санхүүжилтээ авчихсан компаниуд яваад байна. Бодит жишээ яривал БНД-ийн 2 дугаар хороон дээр 2019 онд эхэлсэн зуухан хүүхдийн цэцэрлэгийн ажил өнөөдөр дуусаагүй, 4 дэх жил рүүгээ орох гэж байна.

Тэрбумд хүрэхгүй, төсөвтэй ажил байсан. Гэтэл яамнаас Боловсролын яамнаас санхүүжилтийг нь олгочихсон. Ахиад нэмэлт санхүүжилт шаардлагатай гээд төсөв дээр тусгаад ахиад нэмэлт санхүүжилтээ авчихсан. Гэтэл өнөөдөр ажил нь 80 хувьтай Денатос гэдэг компани. Ингээд ажлыг гацаагаад, цаана нь ингээд орон нутгийн эрх ашиг зөрчигдөөд орон нутгаас сонгон шалгаруулалт хийгээгүй, Боловсролын яамнаас хийчихсэн байдаг. Тэгээд энэ Боловсролын яамныхаа эрх бүхий удирдлагуудтай холбоотой л юм шиг байгаа юм. Ингээд л аргалаад л яваад байдаг. Энийг та нар энэ хуулийн шинэчилсэн найруулгаар яаж хаах гэж байна вэ. Нөгөө талаар тендер зарладаг чадна гэж орж байгаа юм тухайн компаниуд яг тэр төсөвт нь. Гэтэл тендерийн явцад нэмэлт ажил гардаг. Тухайлбал газар шорооны ажил хийсэн чинь шавар намагтай гэдэг юм уу цэвдэгтэй газар гараад ирлээ. Манайх ийм уулын хөрс шорооны нэмэлт ажил хийлээ. Хийнэ гээд орчихсон чинь тэд нар нь шугам илүү татахаар болчихлоо. Ус, дулаан, цэвэр, бохир усны шугам. Тийм эндээс болоод л нөгөө тендерийн ажлын санхүүжилт нэмэгдэх суурь болоод байгаа юм. Тэгээд энэ дээр одоо хэн хариуцлага хүлээх вэ цаашдаа. Энэ тендерийг зарласнаараа орон нутаг уу? Зураг төсөв хийсэн компани уу? Санхүүжилтийн нэмэлт санхүүжилтийг хэрхэн яаж олгох юм?

Энийг энэ хуулиар яаж тусгаж байна вэ гэж.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг хариулъя. Нэгдүгээр нэгдүгээр микрофон.

Ц.Батзул: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн гишүүн Батзул. Чанаргүй асуудлаас эхлээд хариулъя. Бид бол хуулийн төсөлдөө ААН-үүдийн бүх нөөц бололцоо энэ төрд бүртгэдэг, хууль тогтоомжийн дагуу бүртгэдэг бүх мэдээллийг нь давхар хөтлөөд явъя. Тэгээд одоо байгаа бодит нөхцөл, боломж бололцоо, хүчин чадал, машин механизм. ажиллах хүч нь аль аль тендер дээр байгааг нь давхар хөтлөөд явчихъя. Тэр нь давхардахаар байх юм бол энэ нөөц бололцоо хангалтгүй гэдэг үндэслэлээр татгалзаад явъя. Тэгээд бүх тендерүүдийг нь яг энэ асуудал нь зэрэг хөтлөөд явах учраас яг үнэлгээний явцад нь энэ бол нээлттэй ил тод үнэлгээний хорооны гишүүд харагдаад явна.

Хоёрдугаарт нь цүнхний компани гэдэг асуудлын цаана бид нар судлаад үзэхээр яг үнэндээ хэлэхэд Барилгын яамны харьяа нь Барилгын хөгжлийн ассоциациас 7000 ААН-д тусгай зөвшөөрөл олгосон байгаа юм барилгын. Тэгээд цүнхний компани чинь цүнхэндээ заавал тусгай зөвшөөрөлтэй байгаад байгаа юм аль нэг. Замын ч юм уу, эрчим хүчний ч юм уу, барилгын. Гэтэл нөгөө олгосон хүн нь байгуулсан гэрээнийхээ дагуу явцын хяналт огт хийдэггүйгээс болоод тендер дээр энэ нь ингээд илрээд байдаг. Жишээ нь тусгай зөвшөөрөл авах чинь маш өндөр, бараг тендерээс өндөр шалгууруудыг хангаж байж тэр тусгай зөвшөөрлөө авдаг. Тэгээд давхар гэрээгээ байгуулдаг. Тэгээд Барилгын тухай хуулиараа барилгын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгуулсан гэрээний дагуу улирал тутам тухайн шаардлагыг хангаж байгаа эсэх, нотлох баримтаа хангаж явдаг, үзүүлж явдаг. Энэ хяналт байхгүйгээс болоод тендер дээр бас хүчин чадалгүй машин механизм ажиллах, хүчингүй ийм хүмүүс барилгын ажлаа гүйцэтгэж байгаагаас болоод энэ алдаа тендер дээр илэрч гарч ирээд байгаа.

Энэ бол үнэн бодитой байгаа асуудал. Тэгээд бид нар барилгын яаманд бас саналаа тавьж байгаа. Та нар олгосон тусгай зөвшөөрлийнхөө араас нь яваад явцын хяналтаа тавьчих юм бол бид нар энэ асуудал чинь бас тодорхой хэмжээнд цэгцрэх байна шүү дээ.

Дээрээс нь үнэхээр зурсан зураг нь сая яг тийм энийг нь бид нар тухайн цаг минутад тендерийн үнэлгээ хийх явцад систем дээр байгаа мэдээллийг нь шууд бодит цагийн горимоор татаад энэ хүн энэ компани дээр байхгүй юм байна гээд л татгалзаад явах нь гэсэн үг, нөөц бололцоо нь хүрэхгүй гээд л шууд тийм үнэлгээ хийх боломжийг нь бол хуулиар олгож байгаа юм.

Хоёрт нь болохоор угаасаа ААН-үүдийн эзэмшиж байгаа машин механизм, ажиллах хүчний бүртгэлийг нь хууль тогтоомжийн хүрээнд НДЕГ болон Авто тээврийн үндэсний төвийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж авч байгаа. Тэгээд яг энэ мэдээллийн сан дээрээс нь бид нар лавлагааг нь татаад тухайн цаг минутад нь ямар ямар ажиллах хүчинтэй, машин механизмтай гэдгийг нь лавлагаан дээр нь үндэслээд тендерийн үнэлгээгээ хийнэ. Тэгэхээр тэнд тусгай зөвшөөрөл авч байх үедээ бүрдүүлж байсан материалаараа дахиж тендерт оролцох боломжгүй болно оо л гэсэн үг.

Санхүүжилтийн асуудлыг ер нь гүйцэтгэлээс нь түрүүлээд өгөх чинь бол гэмт хэргийн асуудал байгаа. Тэр бол Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээнэ шүү дээ. Хийгдээгүй ажлын мөнгийг нь ямар нэгэн барьцаа мөнгөгүйгээр шууд олгочхож байгаа асуудал бол энэ бол гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаа гэж үзэж байна.

Харин хуулиар бол урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргасан тохиолдолд урьдчилгаа төлбөрийг нь бол түрүүлээд авах боломж нь бол хуулиараа хэвийн, ингээд төсөлд нь туссан байгаа.

Г.Тэмүүлэн: Сангийн сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Сандаг-Очир гишүүн асуултад нэмж хариулъя.

Яг тэр тухайлан төслийн талаар тухайлан тэр компанийн талаар бид нар үзээд танд нэмэлт хариу өгөөд ямар арга хэмжээ авах вэ. Хаана ямар зөрчил байна вэ гэдэг талаар албан бичгээр танд би хариу өгье, өөрөө хариу өгье.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн нэмж тодруулах уу?

Ц.Сандаг-Очир: Энэ худалдан авах ажиллагааг Худалдан авах ажиллагааны газар, яам, төрийн өмчийн компаниуд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Худалдан авах ажиллагааны газар нэгжүүд хийж байгаа, тийм ээ. Эд нар чинь хоорондоо мэдээллийн бааз, тэр юмнууд нь уялдсан юм уу? Жишээ нь дүүргийн худалдан авах ажиллагааны газар дээр тэр компанийн мэдээллүүд бүгд байх бололцоотой юу? Энийг нэг хараад хэлээдхээрэй. Улсын комисст хүлээлгэж өгөх ажилд орон нутгаас ерөөсөө төлөөлөл оролцуулдаггүй. Тэгээд л нөхдүүд ирээд л үзэж хараад л явчихдаг. Орон нутгаас нь ямар ч мэдээлэл байхгүй, авчихсан, авчихсан. Ажил дутуу байна гэж хэлж чаддаггүй. Яг гүйцэтгэлээрээ чанаргүй хийсэн юм байна гээд хэлж чаддаггүй, хэлэх нөхөр байдаггүй. Нэг хотоос ирээд л, яамнаас ирээд л нөхдүүд хүлээлгээд өгөөд л явчихдаг. Энийг цаанаа та нар маань цаашдаа яаж, яах гэж байна. Тэр нэмэлт ажил гарсан тохиолдолд гэдгийг би хэлсэн шүү дээ. Ийм тохиолдолд хариуцлага юмыг хэн хүлээх.

Г.Тэмүүлэн: Батзул хариулъя. Нэгдүгээр микрофон асуултад хариулъя.

Ц.Батзул: Нэмэлт ажлын хувьд үнэхээр тусгай зөвшөөрлийн хүрээнд үзүүлсэн, үйлчилгээ нь чанаргүй байгаад дутуу ажил тооцсон байх юм бол тухайн зургийг зурсан автор нь өөрөө хариуцлага хүлээх ёстой. Тэгээд энэ нь болохоор тухайн Барилгын тухай хуулиараа заачихсан байгаа. Төсвийн тухай хуулиар бас заачихсан байгаа. Тэгээд дээрээс нь Барилгын хөгжлийн төвийн зөвхөн магадлал хийгдсэн, зураг төсөв дээр үндэслээд төсөвт сууж байгаа. Тэгэхээр бас Барилгын хөгжлийн төв ч гэсэн буруу зураг магадлаад тоо хэмжээ нь болно оо гээд баталсан байх юм бол энэ асуудал нь бас дахиад тэр хууль тогтоомжийнхоо хүрээнд хариуцлагаа хүлээгээд явна, захиалагч талаас. Өөр тэрийг нь бол хуулиар хязгаарласан, тийм ерөөсөө гэрээнд тусаагүй ажлыг эндээ ингээд хийчих, энэ нь шат гаргачих энэ цонх энийг нь бол гэрээнд нь тусгаад заачихсан байгаа. Тэгээд улсын комисст хүлээн авах, орон нутгийн тэр асуудлыг нь бол захиалагч, өөрөө байгуулсан гэрээнийхээ хүрээнд комиссоо хэрхэн ажиллуулах талаар бол гэрээндээ тусгаад явах бүрэн боломжтой байгаа.

Энийг нь бол тусгайлсан Тендерийн хууль энэ шинэчилсэн найруулгын төсөлд бол заагаагүй байгаа. Хуулиар ямар захиалагчийнхаа статусаас үл хамаараад нэг л систем ашиглаж байгаа учраас бүх мэдээлэл нь хоорондоо яг тэнцүү хэмжээнд

солилцоод цаг, минутын алдаагүйгээр явж байгаа. Тийм бүх системүүд нь хоорондоо холбогдсон бүх төрийн байгууллагууд нэг систем рүү ороод мэдээллээ оруулж байгаа учраас ямар нэгэн зөрүү бол үүсэхгүй.

Г.Тэмүүлэн: Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Санал хэлэх гишүүд? Баделхан гишүүнээр тасаллаа. Баделхан гишүүний микрофоныг өгье.

Х.Баделхан: Баярлалаа. Хуулийн төслийг бол ерөнхийдөө дэмжиж байгаа. Гэхдээ нэг зүйл дээр анхаарвал энэ дотоодын худалдан авалт, дотоодын компани гэдгийг ер нь бид нар энэ хуулийн төсөл рүү бол дэмжмээр байна. Энэ дотоод худалдан авалтыг олон жил ярьсан. Гэхдээ яг амьдрал дээр хэрэгжихгүй байгаа. Тэр дотоодын компаниуд, би энэ замын салбарыг бол маш сайн мэднэ. Өөрөө тэнд ажиллаж байсан. Одоо сүүлийн үед энэ замын компаниуд бол бүгд дампуурчихсан. Яагаад гэвэл тэнд ажил байхгүй, тендерт орж чадахгүй. Замын техник бол маш их үнэтэй байдаг юм. Нэг гредер авахад нэг тэрбум төгрөгөөр авдаг юм. Гэтэл дэмжлэг байхгүй учраас тэр өмнө байсан том том компаниуд өнөөдөр эргээд харахад бүгд дампуурчихсан байна. Эсрэгээрээ гаднын Хятадын хулхи компаниуд орж ирээд ингээд байгаа.

Тийм учраас ер нь саяын нөгөө мөнгөөрөө хязгаарласныг бол ер нь боливол яасан юм бэ гэсэн надад бол тийм санал байгаа, амьдрал дээрээ. Одоо ер нь аргагүй л Монголдоо хийж чадахгүй гэсэн технологийн онцлогтой, үнэхээр хийж чадахгүй зүйлийг бол бас тендерийн нөхцөл дээр заагаад тэрийгээ ер нь гаднын компаниар хийлгээд, ер нь дотоод ажлаа дотоодын худалдан авалтаа бас дэмжвэл яасан юм бэ гэсэн надад ийм санал байгаа. Замын ажлын өртөг бол их өндөр байдаг юм. Саяын 30 тэрбум гэдэг бол ерөнхийдөө 20 километр зам. Тэгэхээр дандаа гаднын компани байгаа. Яг амьдрал дээр бол тэр том том компаниуд бүгд дампуурчихсан байгаа өнөөдөр. Тэгэхээр үнэхээр хийж чадахгүй, технологийн талаас тийм байвал ер нь гаднын компани оруулж байвал яасан юм бэ? Энийг хуулийн төсөл дээр анхаарч үзээч гэсэн тийм санал байна.

Г.Тэмүүлэн: Баделхан гишүүнд баярлалаа. Сандаг-Очир гишүүн санал хэлье.

Ц.Сандаг-Очир: Тендерийн хууль маань хэрэгжээд нэг 10 орчим жил болж байгаа юм байна аа. Тэгээд ямар ч гэсэн амьдрал дээр туршигдаад, практик дээр туршигдаад бүх процедурын шатанд ямар алдаа оноо байна вэ гэдгийг бас тодорхой харах хугацаа өнгөрсөн гэж ойлгож байгаа юм.

Тийм учраас та нар маань энэ яг бодлого барьж байгаа улсууд, энэ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авч байгаа энэ тохиолдолд энэ ажил дээр ерөөсөө хаана ямар хулгай луйвар гарах тэр бололцоо боломж байгаад байна тэрийг л одоо хаах бүх талаар хаах, энэ л байдлыг л хийж эрх зүйн хувьд хийж өгөхгүй бол энийг магадгүй заримдаа хуйвалдаж тийм хүүдий бий болгож, тэрүүгээр нь бас төрийн өмчийг төсвийн мөнгийг хулгайлах ийм бололцоо, боломж байгаад байна.

Тийм учраас энэ хуулийг зайлшгүй шинэчлэх шаардлага бол нийгэмд бол зайлшгүй байгаа гэж ингэж ойлгож байна. Нөгөө талаасаа энэ хуульд хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт орчихлоо. Тэгээд энэ хуулийн чинь үндсэн бас зарчим алдагдчих вий дээ. Тэгээд энэ хуулийг Эрүүгийн хуульд сая асар том өөрчлөлт орлоо. Авлига, албан тушаалын хэрэг. Энэ тендерийг зарлаж байгаа компаниуд, үнэлгээний хороонд орж ажиллаж байгаа улсуудад энэ хуулийг сурталчлах, энэ субъект нь мөн шүү дээ. Энэ худалдан авах ажиллагаа нь үнэлгээний хороонд орж байгаа нөхдүүд. Хэрвээ энэ албан тушаалаа урвуулан ашиглавал авлига хээл хахуулийн асуудал яригдвал шууд ял хоригдох ийм хатуу чанга хууль гарсан учраас энэ тендерт оролцож байгаа компаниуд мөн Үнэлгээний хороонд орж байгаа төрийн албан хаагч нарыг асар сайн мэдээ мэдээллээр хангах ажлыг хийхгүй бол мэдээгүйгээсээ болоод дарга нарын өгсөн үүрэг чиглэлээр ажиллаж байгаад ингээд дараа нь төрийн албан хаагч нар маань ял авах асуудал хаа хаанаа үүсэх эрсдэл бий болчихсон шүү.

Нөгөө талаар энэ хууль ингэж өөрчлөгдсөнтэй холбогдож, энэ ер нь хуулийн концессыг боловсруулахад энэ компаниудад хувийн хэвшлийнхнээс санал асуулга юмнуудыг хэр сайн авсан юм бол доо. Тендерт оролцож байгаа компаниуд чинь бол яг та нараас илүү энэ Их Хурлын гишүүдээс илүү мэргэшчихсэн, хуулиар мэргэшсэн тендерийн онгорхой цоорхойг асар сайн судалчихсан, тусдаа хуульч, өмгөөлөгчтэй ийм болчихсон байгаа.

Тийм учраас тэд нарын санал хүсэлтийг авч, энэ хуулийг цаашдаа яг шударга явуулах төсвийн хөрөнгийг шамшигдуулахгүй байх энэ талаас одоо энэ олон нийтийн санал хүсэлтийг хэр сайн авсан юм бол? Цаашдаа энэ хэлэлцүүлгийн шатанд ч гэсэн бас энэ боловсрогдсон төсөл нь ийм явж байна. Энэ дээр ахиад санал авах ажлуудыг бид нар зохион байгуулах ажил бас их шаардлагатай л юм шиг надад сан санагдаж байна.

Тэгээд цаг хугацааны хувьд ийм он дуусах гэж байна. Он гарах гэж байна. Ингээд олон нийт шал өөр тийшээ хандчихсан нөхцөлд энэ хуулийн орж ирж байгаад би бас нэг талаас олон нийтийн анхааралд автаж орохгүйгээр ингээд хууль батлагдчих вий дээ? Хувийн хэвшлийнхэнтэй уулзвал асар олон саналуудыг хэлэх байх гэж би бодож байна. Ийм ийм хууль чинь ийм ийм зүйлийг зөрчөөд байдаг юм аа. Амьдрал дээр ингэж дарамт болоод байдаг юм аа. Ийм цоорхой байгаад байдаг юм гэдгээ. Тийм учраас олон нийтийн саналыг авах ажил бол энэ дээр онцгой чухал шүү л гэж би хэлмээр байна.

Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Гишүүд хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлж дууслаа.

Ингээд санал хураалтыг явуулж эхэлье.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя.

Санал хураалтын дүнг танилцуулъя.

Санал хураалтад 10 гишүүн оролцсоноос 7 гишүүн дэмжиж, 70 хувиар дэмжигдлээ.

Ингээд хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин гишүүн танилцуулах уу? Амартүвшин гишүүн танилцуулна.

Ингээд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалд орно. Дөрөв дэх асуудал.

Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан. Өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолоор Засгийн газрын 2019-2022 оны өрийн удирдлагын стратегийн баримт бичгийг баталсан. Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан, Өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Төсвийн байнгын хороонд жил бүр Байнгын хороо хэлэлцэнэ гэж заасны дагуу 2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн танилцуулж байна. Өмнөх хугацаанд стратегийн баримт бичгийн хүрээнд Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасыг төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах, Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр зөвхөн эдийн засгийн үр өгөөжтэй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, орчин үеийн технологийн дэвшлийг ашигласан Засгийн газрын үнэт цаасны арилжааны дэд бүтцийг бүрдүүлэх, болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх тогтолцоог хөгжүүлэх, Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулах, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх зэрэг үндсэн 5 зорилтыг давж ажилласан байдаг аа.

Ийнхүү стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд бид өрийн хэмжээг хязгаарт нь хүртэл тулгаж, зээллэг хийхээс татгалзаж, аль болох гадаад өр, тэр дундаа бондуудын үлдэгдлийг төсвөөс тодорхой хэмжээгээр төлж барагдуулж ажиллана аа. Мөн барих, шилжүүлэх нөхцөлтэй концесс, векселийн өрүүдийг төлж барагдуулан Засгийн газрын өрийн баталгаа гаргахгүй байх чиглэлийг тууштай баримталж ажилласнаар 2016 онд 78.8 хувь байсан ДНБ-д эзлэх Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн харьцааг 2019 онд 55.6 хувь,